Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 04 сар. №007 (017) www.mongolianeconomy.mn

Гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл

Давалгааг дага

Сонгуулийн эдийн засаг



NESTLE компанийн ТУЗ-ийн дарга Петер-Брабек Летматете:

НӨӨЦ БАЯЛГИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭТЭЙ ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ РУУ ОРОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

RM500
Ухах өргөн: 2438мм
Ухах гүн
Нөхөн сэргээх: 406мм
Хөрс тогтворжуулах: 508мм
Жин: 28,417 кг

AP655D Мобил –гинжит
Тракторын жин: 15,420кг
Хучилтын стандарт
өргөн: 2,4м
Тохирох тэгшлүүр:
AS2252C&AS3251C

CB534D XW*
Нягтаршуулах өргөн: 2000мм
Жин ROPS: 11,300 кг

CS533E
Нягтаршуулах өргөн: 2134 мм
Жин: 10,840 кг

ҮРГЭЛЖ ТЭРГҮҮНД БАЙХ **КАТ**-ЫН ЗАМЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД









CAT 14M Хутганы урт: 4,28м, Жин: 21,400кг



Weiler E1250A- Материал зөөх машин



Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК
Утас: 976-11-687588, Факс: 976-11-687587
Вэб: www.wagnerasia.com

WAGNER ASIA EQUIPMENT LLC CAT

Shandong Equipment LLC SEM

КАТЕРПИЛЛАРЫН 100% ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БНХАУ-ЫН
SEM MACHINERY КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ДИЛЛЕР
ШАНДОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК







УТАС: 976-11-687588
976-99007826

“Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх” зээлийн төсөл II шат

ХасБанк Япон Улсын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Жижиг Дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл”-ийн зээлийг олгож байна.





Бизнесийг хөгжүүлэх боломжит урт хугацаа –10 ЖИЛ хүртэл



Өрсөлдөхүйц бага хүү – ТӨГРӨГ 8%, ДОЛЛАР 5.4% (хувьсах, 2012 оны эхний хагас жилд мөрдөх хүү)

XacBank XacBankZuvBank XacBank.mn 1888



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт уурхайчид, ноёд, хатагтай нараа

Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжилд хөдөлмөр, бүтээл, оюун санаагаа харамгүй зориулж ирсэн үе, үеийн уурхайчид, тэдний гэр бүлийнхэн, Монголын нийт ард түмэнд Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан Эрдэс, Баялаг, Эрчим Хүчний Яамны хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн баяр хүргэн мэндчилье.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн далайц, эх орны нийгэм, эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг Монгол хүн бүр мэддэг болсон нь уул уурхайн салбартай аж амьдралаа холбосон уурхайчдын нөр их хөдөлмөрийн үр шим, ач гавъяа билээ.

Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг угтан “Mining Mongolia-90” олон улсын нээлттэй чуулга уулзалтыг “Хөгжилд хөтөлсөн уул уурхай 90 жил” уриан дор зохион байгуулах гэж байна. Чуулга уулзалтад төрийн болон төрийн бус байгууллага, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын аж ахуй нэгжүүд, хөрөнгө оруулагчид, мэргэжлийн холбоод, эрдэмтэн мэргэд зэрэг салбарын бүхий л төлөөллийг хамруулан санал бодлоо солилцох хүсэл, зорилготой байна.

Чуулга уулзалт уул уурхайн салбарын нийт хамт олонд нээлттэй явагдах болно. Иймд та бүхнийг чуулга уулзалтад идэвхитэй оролцохыг урьж байна.

ЭРДЭС БАЯЛАГ,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД Д.ЗОРИГТ

“Mining Mongolia-90” олон улсын нээлттэй чуулга уулзалт зохион байгуулна

Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Ашигт малтмалын газраас “Mining Mongolia-90” олон улсын нээлттэй чуулга уулзалтыг энэ оны 5 дугаар сарын 9, 10-нд Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд зохион байгуулах гэж байна.

Улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам бүр өсөн нэмэгдэж буй уул уурхайн салбарын түүхийг сөхвөл 1922 оноос эхлэлтэй. Анх Ардын Засгийн газрын 1922 оны хоёрдугаар сарын 10-ны өдрийн шийдвэрт Налайхын нүүрсний газрын ашиглалтыг улсын мэдэлд авч хэрэгжүүлэх хугацааг 1922 оны 12 сарын 25-наар тогтоосноор уул уурхайн салбарын хөгжлийн эхлэл тавигджээ. Тухайн үед Нийслэл хүрээний түлшний асуудлыг шийдэх зорилгоор улсаас уул уурхайн салбарт анхаарал тавьж эхэлсэн нь энэ байлаа. Улмаар Ардын Сайд нарын Зөвлөл 1939 оны аравдугаар сарын 6-ны өдрийн 38 дугаар тогтоолоор тухайн үед тус тусдаа удирдлагатай байсан геологийн судалгаа шинжилгээний ажил, уул уурхайн асуудлыг уялдуулан ойртуулж Аж үйлдвэр, барилгын яамны харъяанд уурхай ба ашигт малтмалын трестийг анх байгуулсан түүхтэй.

Уул уурхайн салбар 90 жилийг туулахдаа хөгжлийн түүхэн бүтэц, зохион байгуулалтын олон нэр томъёо, хэв шинж, харъяалал хамааралтай явж ирсэн ч түүхэн цаг үед улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам бүр өссөөр одоо улс орны тэргүүлэх чиглэл болтол өргөжөөд байна. Тодруулбал, уул уурхайн салбар нь 2011 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 20.2 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 69.6 хувь, экспортын бүтээгдэхүүний 89.2 хувийг үйлдвэрлэж байна. Дээрх үзүүлэлт Монголын эдийн засгийг өнгөрсөн жил түүхэнд байгаагүй буюу 17 хувиар өсгөсөн юм.

Цаашид ашигт малтмалын шинэ ордуудын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт уул уурхайн салбарын өмнө тавигдаж байна. Монгол Улс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээр дэлхийн зах зээлийн түүхий эдийн ханшийн хэлбэлзлээс хамгаалагдаж, илүү тогтвортой хөгжих боломж бүрдэх юм. Мөн өвөг дээдсээс өвлүүлсэн эрдэс баялгаа хамгийн орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан олборлон, боловсруулж үр өгөөжийг нь өнөөгийн монгол түмэн хүртэхийн сацуу хойч үедээ өвлүүлэн үлдээх нь төрийн чухал зорилт билээ.

Тиймээс уул уурхайн салбарын өнөөгийн байдлаа хэлэлцэж, хэтийн төлөвөө тодорхойлон, тус салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаад болон дотоодын аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын өмнө тулгамдаж байгаа бэрхшээлүүдийг хэлэлцэж, зөвлөмж гаргах зорилгоор “Mining Mongolia-90” олон улсын нээлттэй чуулга уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Мөн хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалт хайж байгаа төсөл хөтөлбөрүүдийг холбож өгөх, уг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн төлөөллүүдийг уулзуулах, уул уурхайн салбарт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах нь чуулганы чухал зорилт юм.

Чуулганыг сонирхосон хүн бүрийн өмнө нээлттэйгээр зохион байгуулахаар төлөвлөжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг www.miningmongolia90.mn цахим хаяг болон 70115590 утсаар авна уу.

Mining Mongolia 90..

2012 оны 5 дугаар сарын 9-10
Монголын Үйлдвэрчний
Эвлэлийн Соёлын Төв Ордон
Улаанбаатар, Монгол Улс

Зохион байгуулагчид:

ЭРДЭС, БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

Хөгжилд хөтөлсөн 90 жил



Дэлгэрэнгүй мэдээллийг:
www.miningmongolia90.mn, Утас: +976-70115590, Факс: +976-70125590
И-мэйл: registration@miningmongolia90.mn, info@miningmongolia90.mn

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:	Terrence Edwards
Орчуулагч:	Б.Үүрийнтуяа
Сэтгүүлчид:	Х.Хулан
	Э.Зоригт
	Б.Баяртогтох
	Б.Энхцэцэг
	Б.Уганбаяр
	Б.Энхмарт
Дизайнер, Вэб мастер:	Ш.Оюундарь
Маркетингийн менежер:	Д.Барианжав 88800825
	С.Жавхлан 99620780
	Б.Энхцэцэг 99015476
Борлуулалтын менежер:	С.Цэнд-Аюуш

"Economy" ТВ студи

Дэд захирал:	Ц.Буянбат 88112885
Зураглаач:	Ц.Бат-Отгон
График дизайн	Г.Буянбааатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Урин дулааны улирал айлчлаад, эрхэм бизнесмэн Та хөнгөн шаахай, нимгэн цувны хормой дэрвүүлээд, ажлаа гялалзтал бүтээмээр байна уу. Харамсалтай нь, сонгууль хаяанд ирсэн болохоор татсан хаалга болгон эл хуль, уулзсан хүн бүр шахуу "Сонгууль болтол харзная" гэсэн хүлээлтийн маягтай тодорхойгүй хариулт хэлж, ажлыг тань уях нь их байна уу. Ялангуяа унтах ч завгүй уул уурхайн салбарынхны ажлын эрч хүч сонгууль угтаад саарсан талаар манай сэтгүүлч энэ дугаарт орсон "Сонгуулийн эдийн засаг" нийтлэлдээ бичсэн байна билээ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай компани, төр, засгийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа ч ялгаагүй цалгар назгай байдалтай болсон нь анзаарагдаж буй. Гагцхүү түмэн завгүй хүмүүс нь улстөрчид болоод тэдгээрийг тойрон хүрээлэгчид байгаа нь үнэн.

Хэн хүнгүй улстөрөөр амьсгалсан хаврын наран дор "Mongolian Economy" сэтгүүл уншигч, захиалагчдадаа бизнесээ хэрхэн зөв удирдаж, урагшлуулах амжилтын талаар дэлхийн энтэй нэгэн эрхмийн ярилцлагыг хүргэж байна. Энэ хүн бол дэлхийн хүнсний үйлдвэрлэлийн тэргүүлэгчдийн нэг "Nestle" компанийн ТУЗ-ийн дарга Петер Брабек Летматеги. Түүний саяхан Монголд айлчлах үеэрээ манай сэтгүүлд өгсөн эрч хүч бэлэглэсэн сонирхолтой ярилцагыг амтархан уншаарай.

Мөн хаврын хавсрага Улаанбаатарын гудамж талбайгаар нэг хөглөрөх хог новшийг агаарт "бүжиглүүлээд" тун төвөгтэй. Салхины шил, амны алчууртай л явахгүй бол горьгүй. Тиймээс манай сэтгүүл шинэхэн дугаартаа нийслэлчүүд бид хогтой заваан байдлаасаа ангижрах талаар нэгийг бодож, хоёрыг хийх үүднээс хогны менежментийн асуудлыг онцлон хүргэж байна.

Цэвэрч нямбай байдлаараа дэлхийд дээгүүрт ордог Япон орон 1960 оныг хүртэл заваан бохирооров манайхаас ч дор байсан гэвэл Та итгэх үү. Их наран улс аравхан жилийн дотор цэмцгэр хот болж чадсан тухай "Иргэн таны хүсэл эрмэлзлэл гол хөшүүрэг шүү" нийтлэлээс сонирхож болно. Хогоо гаргахаасаа залхуурч, гэрийнхээ цонхоор цацчих нь энүүхэнд байсан япончууд ямар менежмент хэрэглэж тийм богино хугацаанд цэмцийж чадсан байх вэ?

Түүнчлэн хэдий сонгууль дөхсөн ч улсын хөгжил урагшилсаар. Монголын санхүүгийн зах зээлд бондын шинэ эрин ирсэн талаар манай сэтгүүлийн гадаад хэлний редактор Терэнс Эдуардсын бичсэн "Давалгааг дага" нийтлэл сэтгэл баясаасан сайхан мэдээ дуулгана.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

Займагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл



Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм...10

Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан



Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо. ..16

Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл



Манай нийслэлээс гарч буй хогны 60 орчим хувийг дахин боловсруулах боломжтой ч одоогоор огт боловсруулалт хийдэггүй. Дөнгөж 3-5 хувийг нь л хоёрдогч түүхий эд болгон экспортолж байгаа аж...30

Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо



Бидний эргэн тойронд байгаа байгалийн бас нэгэн баялаг болсон агаар, хоосон зайг ашиглаж бизнес явуулж байна. Энэ агуулгаараа байгальд үнэхээрийн ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болно...36

БИЗНЕС

10 Займагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл

14 Ямаа ба кофе

16 Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан

18 Чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх нь компанийн хариуцлага юм

19 Сонгуулийн эдийн засаг

22 Монгол нүүрсний баялгаа “ногоон” нүүрс болгох боломжтой

24 Буцалж буй Ханбогд

24 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд

27 Салхины үнэрээс хуваалцахуй

Эдийн засаг

30 Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл

33 Хүнд ажлын хямд хөлс

36 Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо

40 Давалгааг дага

42 Азийн хөгжлийн загвараас бидэнд сурах зүйл бий юу?

ЭДИЙН ЗАСАГ



Монголбанкнаас өнгөрсөн сард Хэрэглэгчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа хийжээ. Судалгаанд Улаанбаатар хотын есөн дүүргийн 135 хорооны 1013 иргэнийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамруулсан гэнэ. Судалгааны үр дүнг сонирхуулахад, иргэд инфляцийг гурван сарын дараа 16.7 хувь, хагас жилийн дараа 15.0 хувь, жилийн дараа 14.1 хувь болж өснө гэсэн хүлээлттэй гарчээ. Мөн иргэд инфляцийг жилийн дараа дунджаар 9.6 хувь болно гэж үзжээ.

Дэлхийн банкнаас гаргасан Монгол Улсын эдийн засгийн 2012 оны хоёрдугаар сарын тоймд Монгол Улсын хувьд тодорхой бус үе ирээд байна гэж тэмдэглэжээ. Дэлхийн эдийн засгийн байдал эрсдэлтэй байгаагаас эдийн засгийг сөрж байгаа салхины эрч нэмэгдэж болзошгүй. Үүний зэрэгцээ удахгүй болох гэж байгаа сонгууль дотоодын нөхцөл байдлыг улам тодорхой бус болгож байна. Тогтворжуулалтын санд хангалттай хэмжээний хуримтлал үүсэх хүртэл Монгол Улс эрдсийн бүтээгдэхүүн үнийн хэлбэлзэлд их өртөмтгий байна.

2008-2009 оны хямралын үеэр БНХАУ дэд бүтцээ анхаарч, эдийн засгаа дэмжих бодлого авч хэрэгжүүлж байсан бол дэлхийн эдийн засгийн өсөлт буурч буй өнөө үед тус улс дахин ийм арга хэмжээ авахгүй байх магадлал өндөр байгааг анхаарах хэрэгтэй гэжээ.

БАНК САНХҮҮ

Азийн хөгжлийн банкны тайланд Монгол Улсын банкны салбар нь 2009 онд нүүрлэсэн санхүүгийн хямралаас хойш ихээхэн сэргэсэн. Гэвч банкны зээл олголт өнгөрсөн оны эцсийн байдлаар өмнөх жилээс 70 хувиар нэмэгдсэн нь эдийн засаг дахь эрэлтийг өдөөхийн зэрэгцээ банкны эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тиймээс Монголбанкны зүгээс банкуудын эрсдэлд чанд хяналт тавьж, журмаар тогтоож өгсөн зохистой харьцаа, шалгуур үзүүлэлтүүдийн хангалтыг хянаж байх нь нэн чухал гэж зөвлөсөн байна. Монгол Улсын эдийн засаг нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, олон улсын санхүүгийн зах зээл дэх өөрчлөлтөөс нэн их хамааралтай хэвээр байгааг ч дурджээ.

Мөн эдийн засаг, улс төрийн институцыг сайжруулах, байгалийн баялгаас орж ирж буй орлогыг ил тод, хариуцлагатай, шударга удирдахад дунд хугацааны гол сорилт оршиж байна гэж дүгнэжээ.

ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс энэ оны эхний улиралд дэлхийн 113 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2341.7 сая ам.доллар, үүнээс экспорт 883.8 сая ам.доллар, импорт 1457.9 сая ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн сард 164.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 18.8 сая ам.доллар буюу 12.9 хувиар өсчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 28.0 хувь, үүний дотор импортын хэмжээ 34.0 хувь, экспортын хэмжээ 19.1 хувиар тус тус өссөн байна. Экспортын 98.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн, авто ба агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлжээ.



БИЗНЕС

ҮХШХ, “Мерси Кор” олон улсын байгууллагатай хамтран Монгол Улсад анх удаа Инновацийн ваучерын хөтөлбөрийг өнгөрөгч гуравдугаар сараас хамтран хэрэгжүүлж эхэллээ. Уг хөтөлбөр нь жижиг, дунд бизнесийн шинэлэг санаачлагыг дэмжих замаар бизнесийн байгууллагууд болон их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллагуудын хоорондмэдлэг дамжуулах үйл явцыг сайжруулах ач холбогдолтой аж. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд инновацийн талаарх ойлголтыг дэлгэрүүлж, хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой гэнэ. Хөтөлбөрийн эхний ээлжинд инновацийн төслөөр дамжуулан бизнесийн үр ашиг, үйл ажиллагаагаа сайжруулах, мөн шинээр бизнес эрхлэхийг хүссэн Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Увс зэрэг 15 аймгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээс төсөл хүлээн авч, сонгон шалгаруулж байна.

Манай улсад 90 гаруй мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байдгаас 50 мянга нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрт 900 мянга орчим хүн ажиллаж ДНБ-ий 73.7-74.3 хувийг, татварын нийт орлогын 30 орчим хувийг бүрдүүлдэг. 2011-2016 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээ 19.3 их наяд буюу улсын нийт хөрөнгө оруулалтын 54 хувийг эзлэх тооцоот байгаа бөгөөд төрийн үйлчилгээг хөнгөвчилж шуурхай болгох алхмуудыг 2010-2011 онд хийжээ. Төрөөс олгодог тусгай зөвшөөрөл, лицензийн тоог 30 хувиар цөөлж, нэг цэгийн, нэг цонхны, цахим гааль, цахим татвар, бизнес ширээ үйлчилгээнүүд 21 аймаг,

нийслэлд бүрэн нэвтрээд байна.



ГАЗРЫН ТОС

Засгийн газраас газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэхээр боллоо. ОХУ-ын газрын тосны түүхийн эдийн экспортын татварын хувь, хэмжээ бэлэн бүтээгдэхүүнийхээ татвараас өндөр үнэтэйгээр манайд орж ирдэг. Ийм нөхцөлд өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан, иргэдийг ажлын байраар ханган, цаашид хүчин чадал, технологийн шинэчлэлийг эрэлхийлэн ажиллаж байгаа үндэсний компаниудыг татварын хөнгөлөлтөөр дэмжих нь зөв хэмээн үзсэн байна.

ҮЙЛДВЭРЖИЛТ

ҮХШХ-ноос 2012-2016 оны үйлдвэржилтийн зорилтыг боловсруулжээ. Тус хийх ажлын урт жагсаалтад түүхий эдийн нөөц, байршил, бүс нутгийн онцлог, дэд бүтцийн өнөөгийн болоод ирээдүйн чиг хандлага, гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээтэй нягт уялдуулан үйлдвэржилтийг явуулахаар төлөвлөсөн байна. Дээрх хугацаанд улсын төсөв, зээл тусламж, хувийн хэвшил, концессын гэрээгээр хөнгөн, хүнсний чиглэлийн 23 үйлдвэр, барилгын материалын 27, хүнд аж үйлдвэрийн 10, Дархан-Уул, Багануурт үйлдвэр технологийн парк байгуулахаар төлөвлөжээ.

ДЭД БҮТЭЦ



Дархан хотыг “Загвар хот” болгох асуудлыг ҮХШХ-ноос судалж байна. Үүнтэй холбоотой Шадар сайд М.Энхболдоор ахлуулсан “Загвар хотын хөгжлийн хөтөлбөр” боловсруулах Ажлын хэсэг байгуулжээ. Дархан хот нь ОХУ болон БНХАУ-ыг холбосон авто болон төмөр замын тэнхлэгийн дагуу байршилтай, дулааны цахилгаан станцтай, төвийн эрчим хүчний системд холбогдсон хийгээд холбоо харилцаа зэрэг бусад дэд бүтцийн салбар сайн хөгжсөн нь загвар хот болгох шалгуурт нийцэж байгаа аж. Нэг үгээр, Дархан хот нь үйлдвэрлэл, соёл боловсрол, шинжлэх ухааны томоохон төв гэж хэлж болох учраас гадаадын хөрөнгө оруулалтыг татах хамгийн таатай нөхцөл бүрдсэн гэсэн үг юм.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Ойрын таван жилд манай улсад нийт 6877 инженер техникийн ажилтан, 33585 мэргэжилтэй ажилчны хэрэгцээ байгаа гэсэн статистикийг ҮХШХ-ны мэдээлэлд дурджээ. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 2011 оны эцэст 56797 болж, өмнөх оныхоос 2508 хүн буюу



4.6 хувиар өссөн байна. Хүн амын насны бүтцийн онцлогоос шалтгаалж нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа нь ажиллах хүчний эрэлтийг нэмэгдүүлж, ажлын байрны хэрэгцээг бий болгож байгаа аж.

Харин манай улсын бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өнгөрсөн сард 50.1 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 9.3 мянган хүнээр буюу 22.8 хувиар өссөн тухай Үндэсний статистикийн хорооны сарын тайланд туссаныг мөн энд тэмдэглэе.

Эх сурвалж: Засгийн газар, АХБ, Монголбанк



БИЗНЕСМЭН



ЗАЙРМАГНЫ БОРЛУУЛАГЧААС NESTLE-ГИЙН ЗАХИРАЛ ХҮРТЭЛ

Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм.



1944 онд Австрийн Виллах хотод төрсөн Петер-Брабек Летматете Веннын Олон улсын худалдааны их сургуулийн эдийн засгийн ангийг төгсчээ. 1968 онд "Nestle" компанид борлуулагчаар орж, удалгүй шинэ бүтээгдэхүүн боловсруулагчийн албан тушаалд дэвшжээ. Тэрбээр Чили улсад компанийнхаа борлуулалтын менежерээр 10-аад жил,1981 онд Экуадор дахь компанийнхаа захирлаар, 1983 онд Венесуэл дэх захирлаар тус тус ажилласан байна. Түүний хувьд албан тушаал байнга өсч явсаар 1997 онд компанийнхаа гүйцэтгэх захирлаар сонгогдсон юм. Летматете 2008 оныг хүртэл энэхүү албыг хашаад эдүгээ "Nestle"-гийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Түүний шаргуу дайчин, хөдөлмөрч чанар, мөн ажилдаа сэтгэлээсээ дуртай байдал нь өнөөдрийн өндөрлөгт хүргэсэн гэж үздэг. Шүлс асгаруулам амттай зайрмагийг өглөөний нарнаас үдшийн бүрий хүртэл борлуулж, өөрийн бизнесийн бяцхан амжилтдаа хөөрөн баярлаж явсан Петер-Брабек Летматете тухайн үедээ дэлхийд алдартай том компанийг удирдан чиглүүлэгч болно гэж төсөөлж явсан болов уу.

Летматете "Ньюком" компанийн урилгаар Монголд зочилж манай хувийн хэвшлийнхэнтэй бизнесийн арга туршлагаас хуваалцахаас гадна усны асуудлаар сонирхолтой лекц уншиж хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Түүний энэхүү лекц, ярилцлагыг манай сэтгүүл дараа дараагийн дугаартаа нийтлэн хүргэх болно. Харин энэ удаа бизнесийн нууц, амжилтын талаар түүнтэй хийсэн ярилцлагыг хүргэж байна. »

Д.БЭХБАЯР

-Mongolian Economy сэтгүүлийг сонгон ярилцлага өгч байгаа танд талархсанаа илэрхийлье. Хоёулаа таны бизнесийн гараагаа хэрхэн эхэлж байсан түүхээс ярилцлагаа өрнүүлье?

-Би гэдэг хүн Nestle- тэй амьдралаа холбоод 44 жил болчихжээ. Бараг бүхий л амьдралынхаа туршид энэ компанитай хамт байсан гэж хэлж болно. Анх би Австри улсад мөхөөлдөсний худалдаа хийдэг байлаа. Өглөөний нарнаасорой хүртэл мөхөөлдсөө зарж, олсон мөнгөндөө баясаад их л аз жаргалтай байдаг байсан санагддаг. Хурдтай хөгжиж буй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын дунд бизнесээ эхлэх хуучны сайхан аргуудын нэг нь ийм төрлийн жижиг бизнес байсан тул тэр үед тийм ч гайхаад байхаар сонин зүйл байгаагүй юм. Учир нь, бизнесийн гол цөм нь борлуулалт байдаг. Бүтээгдэхүүн хийж, үйлдвэрлэл явууллаа гээд мөнгөжихгүй. Харин тухайн бүтээгдэхүүнийг борлуулж эхлэхэд мөнгө орж ирдэг. Бид ийм л замаар бизнесээ эхлүүлсэн.

-Та кофе уух дуртай юу?

-Миний өглөөний цай гэж хэлж болно. Өглөө босоод хамгийн түрүүнд бага зэргийн шоколад хийсэн аяга кофе уудаг.

-"Nestle" дэлхийд тэргүүлэгчдийн нэг. Амжилтын нууцаасаа хуваалцана уу?

-Амжилтад хөтөлсөн тодорхой хүчин зүйлүүд бий. Нэн тэргүүний хүчин зүйл бол урт хугацааны зорилт. Танай компани урт хугацаанд хөгжиж чадах эсэх нь алсын хараатай шийдвэрүүд гаргаж буй эсэхдээ итгэлтэй байхад оршдог. Ахархан хугацааны өндөр ашгийн төлөө бус урт хугацаанд нийгэм болоод хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангасан үнэт зүйлийг бүрдүүлэх асуудал маш чухал.

Хоёрдугаарт, хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхлыг ихэд хүндэтгэдэг байх хэрэгтэй. Дэлхийн хэрэглэгч гэсэн нэг тодорхойлолт байдаггүй. Та дэлхий дээрх хэрэглэгчдийг хоорондоо яг таг адилхан гэж бодож болохгүй. Бүс нутаг, улс гүрнээрээ өөр өөр байдаг. Тухайлбал, Монгол, Хятад, Японы хэрэглэгчдийг хооронд нь харьцуулбал тэдний хооронд асар том ялгаа бий. Тийм учраас шийдвэр гаргах түвшинд хэт ерөнхий авч үзэхгүй байх нь ихээхэн чухал. Хэрэглэгчдэд нөлөөлөхүйц шийдвэр нь үргэлж тухайн бүс нутгийн түвшинд гардаг.

Гуравдугаарт, санхүүгийн хүчирхэг суурь баазтай байх хэрэгтэй.

"Nestle"-гийн баримталдаг зарчмуудын талаар сонирхуулахгүй юу?

-Манай компани хүмүүсийн насан туршын сайн хүнс, сайхан амьдралын төлөө зогсдог. Үүний төлөө л гол зарчмаа тодорхойлж, дагаж мөрдөж, ажиллаж ирсэн. Сайн хүнс, сайхан амьдралыг нь цогцлоох үүрэг хүлээсэн хүмүүс хамгийн чанартай бүтээгдэхүүн хийхийн төлөө явах нь ойлгомжтой. Үнэндээ бид хүмүүсийг хорвоод мэндлэхээс нь өмнө халамжилж эхэлдэг.

Учир нь жирэмсэн эмэгтэйчүүд манай хэрэглэгчид. Үүний дараагаар хүүхдүүдийг амьдралын гараагаа зөв зохистой эхэлж цаашлаад сайхан амьдарч буй эсэхэд анхаарлаа хандуулдаг. Тухайлбал, нярайн тэжээлийн бүтээгдэхүүн Milo байна. Хүүхдийн өсөлт хөгжилтөд дэмжлэг үзүүлж, өсвөр насанд нь хань болдог бүтээгдэхүүн гэж хэлж болно. Мөн ахмад насны иргэдэд зориулсан бүтээгдэхүүн ч бас бий. Энэ мэтчилэн хүний амьдралын бүхий л хугацаанд "Nestle" кофе болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүнээрээ дамжуулан хамтдаа байдаг. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын бүхий л үеүүд бидэнд хамаатай юм даа.

-Танай компанийн түүхэн туршлага болоод амжилт юуг өгүүлдэг гэж Та бодож байна вэ?

-Аливаа нэг компанийн амжилтад 2-3 голлох хүчин зүйл байдаг. Бидний тухайд, огцом эргэлтэд хөтөлсөн замыг сонгосон юм. Зах зээлд байдаг эсвэл тухайн үеийнхээ хамгийн шилдэг арга замыг сонгож аваагүй. Харин түүнээс илүүтэйгээр зах зээлд тэсрэлт хийсэн тийм л шинэлэг санаанд анхаарлаа чиглүүлсэн. Жишээлбэл, өөрөө уусдаг кофены тэргүүлэгч VR компанийг аваад үзье л дээ. Бид тэр үед яасан бэ гэхээр

кофены борлуулалт, үйлчилгээний зах зээлд жинхэнэ шинэчлэл болсон Nespresso кофе-г гаргаж ирсэн юм. Үүнтэй адил манай компани өнөөдөр цайны ертөнцөд тэсрэлт хийхээр дөнгөж саяхнаас төслүүд хэрэгжүүлээд эхэлж байна. Иймэрхүү жишээг, бизнесийн шинэ санааг та өөрийн компанидаа ч туршиж үзэж болно. Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм. Монголын компаниудын хувьд ч ийм үүд хаалга нээлттэй шүү дээ.

-Nestle эдүгээгийн дэлхийн шилдэгтомоохонкомпаниболохдоо багагүй бэрхшээл саадыг туулсан байх. Хүндрэл бэрхшээлийг туулах нь бизнесийн амжилтын үндэс болдог гэдэг. Та юу гэж хариулах вэ?

-Амьдралд хэцүү асуудал бишгүй тохиолддогийн адилаар миний бие энэ компанид 44 жил ажиллахдаа маш олон саад бэрхшээлтэй тулгарч явлаа. Хамгийн гол нь чиглэлээ зөв тогтоож, өөрөөр хэлбэл, өгөөж сайтай чигийг тууштай барьж явах нь эрсдэл саадын алийг нь ч ажралгүй өнгөрөөнө гэсэн үг. Улмаар та өөрөө бэрхшээлийг боломж болгон хувиргах арга замыг төвөггүйхэн олж чаддаг болно. Эрсдэл, боломж хоёр хоорондоо маш ойрхон оршдог. Зарим үед энэ нь тухайн хүний сэтгэлгээний л асуудал байдаг. Сайнаар харвал маш том саад бэрхшээл дундаас сайхан боломж олддог.

-Бизнесийн сайн удирдагч гэж ямар хүнийг хэлэх вэ?

-Дэлхий дээр бизнесийн нэр хүндтэй, алдартай эсвэл танил бус удирдагчид надад олон бий. Миний хувьд сайн удирдагч гэж өөрийн компанийн үйл ажиллагааг нэг шатаас нөгөө рүү шилжих үйл явцад бодитой тус хүргэж чаддаг хүнийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, жинхэнэ удирдагч хэзээ нэгэн цагт сэтгэл зүтгэлээ зориулсан компаниа орхиод явах тохиолдолд тухайн компани нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадсан байдаг. Ийм хүн бол удирдагч мөн.

-Монголчуудын хувьд компанийн нийгмийн хариуцлагыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх тухай ярьж эхлээд байгаа. Манайхан үүнийг түлхүү мөнгөн хандив, янз бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх гэж ойлгодог. "Nestle" нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

-Энэрэнгүй сэтгэлээр бэлэн мөнгө өгөөд байх нь нийгмийн хариуцлага үнэндээ биш. Бидэнд хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үндсэн үүрэг бий. Өршөөнгүй сэтгэлээр мөнгө тараагаад байх эрх ерөнхий захиралд ч байхгүй. Өглөгч загнах нь хувьцаа эзэмшигчдийн хувийн мөнгөнд л хамаатай асуудал. Хэрэв хүн өөрийн мэдлийн мөнгөөр ямар нэг зүйл хийхийг хүссэн бол тэр хүний эрх. Гэхдээ ерөнхий захирал, удирдлагуудад хувьцаа эзэмшигчдийн мөнгийг хэрэглэх, хамаагүй зарцуулах асуудал байж болохгүй л дээ.

Миний бодлоор нийгмийн жинхэнэ хариуцлага гэдэг нь компанийн зүгээс голлох бодлого чиглэлдээ хувьцаа эзэмшигч болон нийгэмд зориулсан үнэт зүйлийг бий болгох асуудлыг сайтар тусгаж өгсөн байхыг хэлэх болов уу. Компанийн нийгмийн хариуцлагыг хүртээмжтэй үнэт зүйлийг бүтээх гэж нэрлэдэг. Бид ингэж ойлгож, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн.

-Тухайлбал?

-Энэ бол их энгийн зүйл. Та хотын гадна нэгэн тосгонд шинээр гарч ирж буй зах зээлд чиглэсэн үйлдвэртэй боллоо гэж бодъё. Гэтэл бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй тул нийгэм дэх нөлөөлөл тэр хэмжээнд маш томорч, асуудал үүснэ гэсэн үг. Тиймээс та үйлдвэрээ барихаас өмнө хүмүүсээ бэлтгэж эхлэх хэрэг гарна. За тэгээд ханган нийлүүлэгч олдохгүй, хэрэгтэй механик, цахилгааны мэргэжилтэй хүмүүс ч олдохгүй болно. Тэднийг сургаж авах шаардлагатай тулгарна. Мөн эргэн тойронд байгаа ханган нийлүүлэгчид чанартай нийлүүлэлт хийх үү, үгүй юу гэдэгт итгэлтэй байх ёстой.

Таны бизнесийн зүгээс үзүүлж буй нийгэм дэх нөлөөлөл маш том учир та нийгэмд өөрийн гэсэн үнэ цэнийг бий болгох шаардлага гарна. Жишээлбэл, тухайн тосгон хаягдал усыг цэвэршүүлэх эх үүсвэргүй бол тийм төрлийн станц барих хэрэгтэй. Үүний дараа та тосгоны иргэдийг бохир усаа ус цэвэршүүлэх станц руу хийхийг зөвшөөрнө. Энэ нь таны нийгэмд тулгамдсан асуудалд



оролцож буй нэг хэлбэр болох юм.

Компанийн нийгмийн хариуцлага бол ажил хэргээ зөв зохистой явуулахын хажуугаар үүргээ ухамсарлаж нийгэм дэх үнэт зүйлийг бэхжүүлэхэд оролцоогоо чиглүүлэх гэж ойлгож болно. Энэ нь манай компанийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэг арга барил юм.

-Дэлхийн бизнесийн чиг хандлага хаашаа явж байна вэ?

-Бид одоо их эгзэгтэй эмзэг үед байна. Бидний урьдчилж хараагүй олон өөрчлөлт болсоор байна. Тухайлбал "Арабын хавар" тэргүүтэй олон хямралыг нэрлэж болно. Нөгөө талаас, эрэгээр харвал асар хүчирхэг ардчилсан хөгжил байна. Дэлхий дээрх хүн бүрт хүртээмжтэй шинэ боломж, шинэ үүрэг хариуцлага гарч ирж байна гэсэн үг. Сайхан амьдралд хөтлөх сайн хүнсийг илүүтэй чухалчилдаг компанийг төлөөлөн Монголд ирсэн бизнесмэнийн хувьд ирэх жилүүдийг, ирээдүйг өөдрөг сэтгэлээр харж байна.

-Дэлхий дээр кофены олон компани бий. Танай компанийн хувьд өрсөлдөгчөө хэрхэн харж, үнэлж дүгнэдэг вэ?

- Nestle бол ямар ч эргэлзээгүйгээр дэлхий дээрх кофены хамгийн том компани гэж хэлнэ. Бид бусдыг их



ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭТЭЙ ШИНЭ УУ ОРОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

хол орхисон гэж боддог. Өнөөдөр дэлхий дээрх 100 аяганы 25 нь Nes-Cafe-гаар тамгалагдсан байдаг. Бид зах зээлд өөрсдийн бизнесээ тогтвортой хөгжлийн замаар хөтлөн авч явж, манлайллаа тэр хэмжээнд дээшлүүлэхийг зорьдог. Магадгүй бусад компани кофенд илүү ач холбогдол өгч ажиллаж байгаа байх. Гэвч бидний хооронд маш том ангал бий. Тэр бол бидний манлайллыг өдийг хүртэл авч явж байгаа онцлог хөшүүрэг юм. Манай шинэ кофены төрлүүд тухайлбал, NespressoNesCafe, Dolce, Gusto мөн удаан хугацаанд хадгалж болдог Cappuccino гэх мэт бүтээгдэхүүн байна. Бид янз бүрийн хүсэл сонирхолд тохирсон бүхий л төрлийн кофены хэрэглээг бий болгож чадсан.

-Монголын уул уурхайн баялаг дэлхийн анхааралд орж, үндэстэн дамнасан корпорациуд хэдийнэ манайд үйл ажиллагаа явуулж байна.Таны хувьд Монгол орноос ямар шинэ боломжуудыг харж байна вэ?

-АНУ-ын Вашингтон хотод байрладаг Дэлхийн банкны дэргэдэх Төр, хувийн хэвшлийн түншлэлд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Германы Усны нөөцийн группын даргынхаа үүднээс би Монголд хоёр ч удаа ирсэн. Өмнө нь ирэхдээ “Монгол дахь боломжууд ба усны менежментийг хэрхэн сайжруулах вэ” гэсэн асуудлаар Монголын Засгийн газартай ярилцаж байлаа. Тэр үед би энэ удаагийнх шиг Nestle-гийн захирлын үүднээс ирээгүй.

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийг миний хувьд бахдан хүлээн авч, ихээхэн дэмжиж байна. Танай оронд улс орноо хөгжүүлэх, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, мөн шинэ бизнесийн олон боломж байгааг харж байна.

- Та усны асуудлаар дэлхийг төлөөлж ажилладаг хүн. Ер нь усыг хэн хамгаалах вэ?

-Ус бол хүн төрөлхтөний хамгийн үнэтэй түүхий эд. Иймд хүн бүр усыг хайрлаж хамгаалах ёстой. Энэ бол ямар нэг хувь хүн, албан байгууллагын голчлон хариуцах асуудал бус дэлхий дээр хүн болж мэндэлсэн иргэн бүрийн үүрэг хариуцлага юм. Харамсалтай нь бид урт хугацааны тогтвортой амьдралын үндэс гэдэг үүднээс нь устай хүндэтгэлтэй харьцдаггүй. Тийм л учраас өнөөдөр бид ингэж их усны асуудалд санаашраад санаа тавиад байгаа хэрэг л дээ.

-Монгол Улс хүрэн эдийн засгаас ногоон руу шилжих тухай мөн л ярьж байна. Та ямар зөвлөгөө өгөх вэ?

-Ногоон эдийн засаг хэмээх чиг хандлага дэлхий дээрх олон орны эдийн засагт үндэс суурыа баттай олжээ. Копенгаген хотноо долоо хоног үргэлжилсэн дэлхийн нийтийн дээд хэмжээний Ногоон уулзалтад оролцож байхдаа энэ асуудал бүх нийтийн зовнилыг хүртэж эхэлснийг мэдэрсэн. Байгалийн нөөцийг ашиглаж буй өнөөгийн арга барил тогтвортой бус гэдгийг бид ойлгож байгаа. Одоогийнх шиг нөөц баялгаа ашигласаар байвал энэ дэлхий дээрх 11 тэрбум хүнийг байгаль яагаад ч тэжээж, бас аз жаргалтай амьдруулж чадахгүй юм. Бидний хувьд е. Ногоон эдийн засгийн үндсэн уриа хэт материаллаг хэрэглээг халъя л гэсэн үг шүү дээ. Дэлхийн олон орон энэ уриаг хэрэгжүүлээд Засгийн газрынхаа нэн тэргүүний бодлого болгоод явж байна.

-Та Монголын бодлого тодорхойлогчидтой уулзаж усны асуудлаар ярилцсан байгаа. Манай төрийн түшээдийн хандлагыг та юу гэж дүгнэж байна вэ?

-Анх Давосын уулзалтын Байгалийн баялгийн хэсгийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой уулзаад ихэд гайхан биширч билээ. Намайг усны талаар ярьж байхад, тэрбээр над руу эргэж хараад “Юу гээч таны саяын хэлсэн зүйлс чинь Монгол Улсад дэндүү их хамааралтай юм байна. Та бидэндтэй хамтарч ажиллах тухай бодож үзээрэй” гэж билээ. Энэ удаагийн миний айлчлал бидний ярилцсан асуудлуудын хүрээнд хийсэн ажил биш. Харин өнгөрсөн оны зургадугаар сард би Монголын Засгийн газраас зохион байгуулсан усны чуулга уулзалт дээр Монголд тулгарч буй сорилтуудын талаар санал бодлоо хэлэх зорилгоор оролцсон юм. Өдийг хүртэлх хугацаанд бид усны асуудлын гүнд бага ч гэсэн орж чаджээ.

Миний хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын хамтаар байгаль орчны тунхагт гарын үсэг зурсандаа маш их баяртай байна. Уулзсан хүмүүсээс харахад Монголын ирээдүйд усны асуудал ямар их ач холбогдолтойг ийм хэмжээнд ойлгож ухаарсан байгаад миний сэтгэл их хөдөлсөн. Тэдэнд усны төлөөх сэтгэлийн болоод улс төрийн чин хүсэл эрмэлзлэл байгаа нь хамгийн сайн зүйл юм. ■

САЙХАН АМЬДРАЛ, ЧАНАРТАЙ ХҮНС

Nestle нь дэлхийн хүнсний үйлдвэрлэлийн хамгийн том концернуудын нэг юм. Уриа нь сайхан амьдрал, чанартай хүнс. Тус компанийн төв оффис нь Швейцарид байрладаг. Тэртээ 1866 онд Генри Нестле бага насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор Farine Lactee гэдэг хөхүүл хүүхдийн нэмэлт тэжээлийг бүтээснээр тус компанийн үндэс суурь тавигдсан түүхтэй. Үүнээс хойш компанийн үйлдвэрлэл өргөжсөөр өнөөгийн байдлаар 8,000 гаруй хүнс тэжээлийн бүтээгдэхүүнийг таван тивд борлуулж байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс Nestle нь шинжлэх ухааны судалгаа, техникийн боловсруулалтад ихээхэн хөрөнгө оруулдгаараа ялгарч чаддаг аж. 2009 онд гэхэд л хоёр тэрбум швейцарь франкийг шинжилгээ судалгаанд зарцуулжээ. Дэлхийн хэмжээнд 23 судалгааны төв, 280 салбар компанитай. Хүнсний бүтээгдэхүүн хүний биед хэрхэн нөлөөлдгийг судалдаг “Nestle” шинжлэх ухаан судалгааны төвд нь 5000 хүн ажилладаг.

84 оронд байрлах 456 үйлдвэрт нийтдээ 280.000 хүн ажилладаг. Хүнсний бүтээгдэхүүнээс гадна гоо сайхан болон эм зүйн салбарт олон хувьцаа эзэмшдэг дэлхийн хүнсний үйлдвэрлэлийн хамгийн том компани юм.


“Nestle” –гийн бүтээгдэхүүн

Кофе, сүүн бүтээгдэхүүн, хүүхдийн тэжээл, цэвэр ус, хуурай өглөөний хоол, тусгай тэжээл, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, соус, хоол амтлагч, гоймон, шоколад, жигнэмэг, амьтны тэжээл, эм зүйн бүтээгдэхүүн, гоо сайхны бараа бүтээгдэхүүн зэрэг юм. ■

ТҮҮХ

ЯМАА БА КОФЕ

Өдрийн цагт нэгэн үл мэдэгдэх бутанд ургах жижигхэн улаан жимс идсэний дараа ямаанууд нь цовхчиж, бүжиглэх мэт авирлах болсныг хоньчин анзаарчээ. Ингээд Кальди хэрэг дуртай ямаануудынхаа иддэг жимсийг өөрөө идэж үзжээ. Тэгтэл түүний сэтгэл санаа нь ихэд хөдөлж, аз жаргалыг мэдэрсэн байна.



Х.ХУЛАН

Кофены тухай олон түүх бий. Эдгээрээс хамгийн түгээмэл нь Эфиопын хоньчин Кальди ба түүний ямаануудын тухай домог. Өдрийн цагаар нэгэн үл мэдэгдэх бутанд ургах жижигхэн улаан жимс идсэний дараа ямаанууд нь цовхчиж, бүжиглэх мэт авирлах болсныг хоньчин анзаарчээ. Ингээд Кальди хэрэг дуртай ямаануудынхаа иддэг жимсийг өөрөө идэж үзэв. Тэгтэл түүний сэтгэл санаа нь ихэд хөдөлж, аз жаргалыг мэдэрсэн гэдэг. Болсон явдлын талаар гайхсан Кальди сүмийн ламд мэдэгдэв.

Ер бусын жимсний тухай сонссон лам үйлчилгээг нь судлахаар шийджээ. Ингээд тэрбээр кофены модны үр жимсийг чанаж, ханд бэлтгэсэнээр энэхүү эрч хүч оруулдаг энэхүү ундааг лам нар шөнийн залбирлын үеэр хэрэглэж, нойрмоглохоо больсон байна. Үүнээс хойш кофег хэрэглэх болсон гэдэг.

“Нескафе”-гийн түүхээс

“Nestle” компанийн брэнд бүтээгдэхүүн “Нескафе”-ны утгын талаар Та бодож байсан уу? Энэ үг нь “Нестле” ба “кофе” гэсэн хоёр үгний нийлмэл юм. Анх

1930 онд Бразилийн Засгийн газраас Швейцарийн “Nestle” компанид кофены үрийг хадгалах арга олох хүсэлтийг тавьсан байна. Тухайн үед тус компани нь хоол хүнс боловсруулах үйлдвэрлэлээрээ бизнесийн ертөнцөд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэгч болж чадсан байжээ. Ялангуяа бүтээгдэхүүнийг удаан хадгалахын тулд шингэн сүүг хуурай сүү болгох арга технологиороо “Nestle” нэрд гарсан байв.

Бразилийн кофе тариаланчид кофены баялаг ургацаа хадгалах, боловсруулах асуудалтай жил бүр тулгарсаар байв. Түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх технологигүйн улмаас кофены асар их нөөц үр ашиггүй хаягддаг байлаа. Макс Моргенталераар удирдуулсан судалгааны баг кофег хадгалдаг болгохын тулд бүхэл бүтэн найман жилийн турш уйгагүй хөдөлмөрлөжээ. Кофены амт, үнэрийг алдагдуулахгүйгээр, зөвхөн халуун ус хийхэд уусдаг кофены бэлдмэлийг 1938 оны дөрөвдүгээр сарын 1-нд Швейцарийн Орб хотхонд анх худалдаанд гаргалаа.

Өнөөдөр кофег хүссэн хүн бүр хэрэглэдэг. Гэтэл 1940-өөд оны үед кофе тэр бүр иргэдэд олддоггүй байв. Жишээ нь “Нескафе”-г Германд анх 1943 оноос эхэлж зардаг болсон ч нисгэгч болон онгоцны багынхан л уух эрхтэй. Дэлхийн II дайны үед “Нескафе”-ийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэн байна. Бэлдэхэд энгийн, сэргээх үйлчилгээтэй энэхүү ундааг цэргүүд уух дуртай байв. Удалгүй тус кофе нь Англи, Франц, Америк, Итали, Япон зэрэг оронд танил болсон билээ.

“Нескафе” нь өнөөдөр дэлхийн хэмжээнд хамгийн их уух дуртай уусмал кофе юм. Таван тивийн 150 оронд борлуулдаг энэхүү кофег секунд тутамд 4600 аягыг уудаг гэсэн судалгаа байдаг. Энэ нь өдөрт 397 сая аяга халуун “Нескафе”-г хүмүүс уух байна гэсэн үг.

“Нескафе”-гийн гол төрлүүд:

Зэрэглэлээр: Өдөр тутмын, дээд зэргийн, дээдийн дээд зэргийн, коффеингүй.

Төрлөөр: Сонгодог, эспрессо, каппучино, латте макиато, кафе о-лэй, кафе о-чоклад, фраппе, экспресс, крема, грийн бленд. ■

ӨДРИЙГ АЯГА ХАЛУУН КОФЕГООР ЭХЭЛДЭГ ҮҮ?



Та шинэ өглөөгөө хэрхэн угтдаг вэ? Дэлхийн хүн амын 82 хувь өдрийг аяга халуун кофегоор эхэлдэг гэсэн судалгаа байдаг. Кофе нь хамгийн өргөн хэрэглээтэй арван барааны жагсаалтны хоёрдугаарт буюу газрын тосны дараа ордог.

Кофег 70 орчим оронд үйлдвэрлэдэг бөгөөд эдгээр улс орны экспортын орлогын 50-иас дээш хувийг кофены худалдаанаас олдог байна. Нийт 125 сая хүн тус бизнест хамрагдсан байдаг аж. Кофены хамгийн өргөн тархсан хоёр төрөл бол “Арабика” ба “Робуста” юм. Нийт хураан авч байгаа кофены 70 хувийг Африкаас гаралтай “Арабика” кофе эзэлдэг. Энэхүү төрөл 240 хоногт боловсордог аж. “Робуста” төрөл нь дэлхийн кофе үйлдвэрлэлийн 30 хувийг хангадаг, “Арабика”-аас 2-4 хувиар илүү хүчтэй аж.

Олон жилийн турш кофег эрүүл мэндэд хортой нөлөөлөл үзүүлдэг гэж үздэг байсан. Сүүлийн 200 жилийн турш хамгийн их судлагдсан зүйл бол кофе. “Шинжлэх ухааны орчин үеийн судалгаагаар кофены тунг тааруулж уувал эрүүл мэндэд аливаа муу нөлөөлөлгүй, харин ч олон давуу талтайг харуулж байна” гэж Цюрихийн Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны эмч доктор Роберто Корти хэлжээ. Кофены гол бүрэлдэхүүн коффеин нь хар цай, коланд ч байдаг. Гэсэн хэдий ч хүний өөрийн эрүүл мэндийн байдлын онцлогоос шалтгаалж, хэдий хэмжээний кофе уухаа өөрөө тохируулах хэрэгтэй. Мэдээж зүрх судас, ходоод, бамбай булчирхайн эмгэгтэй хүмүүс, жирэмсэн эхчүүдэд таатай биш.

Ихэнх тохиолдолд өдөрт нэгээс хоёр аяга кофе уухыг хэвийн хэрэглээ гэж үздэг байна. Их хэмжээгээр ууж, хэвшил болоогүй хүнд үр нөлөө нь шууд мэдрэгддэг.

• Ухаан санааг хурцалдаг. Коффеин анхаарлыг төвлөрүүлж, ой ухааны тогтоох чадварыг сайжруулдаг. Мөн толгой өвдөж байгаа үед нэг аяга кофе уухад толгойны өвчин намдана. Сүүлийн үед өргөн тохиолдох болсон Альцхаймарын өвчинд кофены хэрэглээ нөлөөлдөг болох нь тогтоогдсон. Канадад нэгэн сонирхолтой судалгааг 1991 онд явуулжээ. 65 наснаас дээш нийт 6434 хүнийг анх өвчлөхөөс нь өмнө судалгаанд хамруулсан байна. Таван жилийн дараа буюу 1996 онд амьд үлдсэн 4615 ахмад настны 194 нь Альцхаймераар өвчилсөн гэж тогтоогдсон. Уг өвчин тусаагүй хүмүүс кофег байнга хэрэглэж, хөдөлгөөнтэй байсан аж. Үүнтэй адил жишээ Португалид ч гэсэн гарсан байна. Иймд кофе Альцхаймарын буюу тархины ой ухааны өвчлөлийн эрсдэлийг бууруулдаг.

Аливаа хэрэглээний тунг тааруулж хэрэглэвээс эм ч болно, тус ч болно. Харин хэтрүүлбээс хор болохыг санаж явахад илүүдэхгүй. Кофе ч мөн адил. ■



АМЬДРАЛ

ЭРХ, БЭРХИЙН ЭН ТЭНЦҮҮ УХААН

Амьдралд сурчихсан байхад илүүдэхгүй зүйл бишгүй бий гэдэг үүднээс Авирмэд Уранчимэг хоёр хүүхдүүдээ зуны амралтаар зориуд хөдөө явуулж мал хариулах, сүү сааль бэлдэх, цагаан эдээ боловсруулах зэрэг монгол ахуйд сургадаг.

Б.ЭНХЦЭЦЭГ

Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо.

...Үүднээсээ цэмцийн гэрэлтэх цайвар өнгө будгын хослол, мэнд мэдэж, инээмсэглэх гэр бүлийн гишүүд, тансаг гэхээсээ илүү тэжээллэг хоол, унд, дулаан тохилог орчин, ах зах, эмх цэгц, найрсаг өрнүүн яриа бүгд энэ гэр бүлийн амьдралын өнгө.

Өнөө үед өнөр бүлд тооцогдох Х.Авирмэдээр овоглосон энэ айл хоёр хүү, хоёр охинтой. Айл гэрийн ноён нуруу Авирмэд ЭХГ-ын Техник, хяналтын газрын даргаар ажилладаг. Түүний хэлэх дуртай үг нь “Дулаан явбал мянган лан”. Тэрбээр дулааны инженер мэргэжилтэй. Гэвч түүний хувьд өөрийн гэр бүлийн “дулаан”-ыг хадгалах нь Монгол Улсын хэдэн зуун мянган айл өрхийг дулаан суулгахтай адил хамгаас чухал зүйл. Нисгэгчийн хүүхэд нисгэгч, эмчийн хүүхэд эмч гэдгээр Авирмэдийн шийрийг хатаах дараагийн дулааны инженер бол том охин А.Пагмадулам нь. Тэрбээр ШУТИС-ийн IV курсийн оюутан. Харин удаах охин А.Саранчимэд нь МУИС-ийн Хими, технологийн ангийн нэгдүгээр курсэд суралцдаг. Хүүхдүүдийнх нь сурлага, хүмүүжлийн асуудал голчлон аавынх нь нуруун дээр бууна. Буудаг ч гэж дээ, эцэг хүний үүрэг хариуцлагаа ухамсарлаж, Авирмэд энэ асуудлыг өөртөө түлхүү хамаатуулан ойр байлгах дуртай гэх үү дээ. А.Баасанчимэд, А.Мягмарчимэд хэмээх хоёр хүү нь “Эхлэл” дунд сургуулийн “толгой өвтгөсөн” өнөөх тоо гэгчийн үнэмлэхүй аваргууд. Тэднийг ирээдүйд инженерүүд болгох хүсэл эрмэлзлэл аав, ээжид нь бий. Гэхдээ хүүхдүүд нь өөрсдийн хүсэл сонирхлоо даган ямар ч мэргэжил эзэмшсэн түүндээ үнэнч, жинхэнэ эзэн нь байхыг эцэг эх нь чухалчилдаг. Боломжийн амьдралтай олон аав ээж хүүхдүүдээ болж өгвөл сургуулиас нь гаргаад ч хамаагүй бушуухан гадаадад сургуульд явуулах сонирхолтой байдаг. Харин дундаас

дээш түвшний амьдралтай энэ айлын боловсролын систем олны жишгээс арай ондоо. Хамгийн түрүүнд арван жил, бакалаврын боловсролыг заавал Монголдоо эзэмших ёстой бөгөөд үүний дараагаар харин гадаадад мэргэжил дээшлүүлж болох гэнэ. Тэдний бодлоор учир зүйгээ олоогүй хүүхэд хэтэрхий эрт харийн оронд суралцаад ирэхээр өмнөхөө мартаж, мэддэг чаддаг нь хоёрын хооронд гурвын дунд болох талтай аж.

“Айлд эр хүний нэрээр ороод эмэгтэй хүний нэрээр гардаг юм. Гол ноён нуруу өрхийн тэргүүн ч гэлээ өрх гэр өнгөтэй өөдтэй байхын ихэнх хувийг эмэгтэй хүн нуруундаа үүрдэг юм шүү” хэмээн охиддоо аминчлан захидаг гэрийн эзэгтэй Ц.Уранчимэг 10 гаруй жил ажил амьдралаа холбосон “Ээрмэл”-ийн үйлдвэрээ орхиж, зөвхөн дөрвөн хүүхдээ хайр халамжаа бүрнээ зориулахаар шийдээд багагүй хугацаа өнгөрчээ. Гэхдээ тэрбээр гэртээ сууж, үр хүүхдээ бөөцийлөхийн сацуу “Удирдлагын академи”-д Бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж амжжээ. Түүний дипломын ажил “Гэр бүлийн стресс” гэсэн сэдэвтэй байсан нь тун ч сонин. Хүнийг хүн болгоно гэдэг зөвхөн хоол унд, хувцас хунар бэлдэж өгөхийн нэр биш гэдгийг энэ гэр бүлээс харж болох. “Ирээдүйн өрхийн тэргүүн, айлын эзэгтэй манайд өсч байна” хэмээн тулган дахь галаа бадраагаад хэдийнэ 22 жил болсон дөрвөн хүүхдийн ээж, аав өгүүлж сууна.

“Хайр нь дотроо хал нь гадна” гэж өвөг, дээдэс маань зүгээр ч нэг хэлчихээгүйг санагалзахад хүргэсэн тус гэр бүл хүүхдийнхээ хүмүүжилд анхаарахдаа бодлогын хувьд эрх, бэрхийг эн тэнцүүхэн эдлүүлдэг онцлогтой. Тухайлбал, гэр бүлийн тогтсон дүрэм журмын дагуу эднийд урамшуулал ба шийтгэлийн систем адилхан үйлчилдэг. Буруу зүйл хийвэл хүүхдүүд нь хэсэг хугацаанд дуртай зүйлээ хийх хориотой, харин сайн зүйл хийж, амжилт гаргавал гэр бүлээрээ баяр жаргалаа хуваалцаж, гадуур хоол идэж, үзвэр үзэх жишээтэй. Түүнчлэн тогтсон заншлаас нь товчхон сонирхуулбал охид хөвгүүд ээлжээр гэрийн ажил хийх үүрэгтэй. Гэхдээ энэ гэрт эр хүнээр хог асгуулах, угаалгын өрөө цэвэрлүүлэхийг цээрлэдэг. Харин эрчүүд нь дотуур хувцас, оймсоо эмэгтэй хүнээр яасан ч угаалгах ёсгүй гэнэ лээ. Бясалгал хийх дуртай Уранчимэг хүүхдүүдээ ч мөн тэвчээр тайвшралын ухаантай танилцуулжээ. “Ууртай хүн тайван хүн хоёрын бодох сэтгэх нь хүртэл өөр” гэдэгт итгэдэг түүний хувьд ирээдүйн хүргэн, бэрдээ ч бясалгал хийдэг байх гэсэн шалгуур тавина гэдгээ нуугаагүй. Өөрийгөө хатуу ширүүн хүн гэж тодорхойлдог ээж нь хүүхдүүддээ хүнийг ганцхан үнэлдэг зүйл бол хүн чанар л байдаг хэмээн захидаг. Харин охидуулдаа хөнгөн хуумгай хөдөлснөөс үүдэн үнэ хүндээ алдах тохиолдол олон байдаг тул ялангуяа эмэгтэй хүн өөрийн үнэт чанараа чандлах ёстойг тусгайлан сургамжилдаг.

Амьдралд сурчихсан байхад илүүдэхгүй зүйл бишгүй бий гэдэг үүднээс Авирмэд, Уранчимэг хоёр хүүхдүүддээ зуны амралтаар зориуд хөдөө гаргаж мал хариулах, сүү сааль бэлдэх, цагаан эдээ боловсруулах зэрэг монгол ахуйд сургадаг байна. Хотын тэд яг л нүүдэлчин монголчуудын хэмнэлээр зуны өглөө 05.30 цагт босч, хөдөөний бүх ажлыг хийж дадсан гэнэ. Харин хотын соёлын тухайд ээж нь одоогоос хэдэн жилийн өмнө дөрвөн хүүхдээ “Lady” төвийн хатагтай ноёд бэлтгэх сургалтад хамруулжээ. Хаана ч очиж, хэнтэй ч уулзаж, зоог барилаа гэсэн нүүр бардам өөрийгөө авч явах соёл хүмүүжилтэй байна гэдэг сайхан. Харин тэдний ирэх зуны төлөвлөгөө гэвэл англи хэлний сургалтад суралцаж мэдлэгээ дээшлүүлэх.

Аав, ээж гэдэг хатуудаа хатуу зөөлөндөө зөөлөн хүмүүс. Хүүхдүүдийнхээ үерхэл нөхөрлөлд хэдий хатуурхдаггүй ч тэд захих, хэлэх анхааруулах зүйл мундахгүй. Хүүхдүүддээ юун түрүүнд хүнийг хүнлэг чанараар нь үнэлж байхыг захидаг. Боломжтой айл гэхээрээ л хүүхдийнхээ хүсэл бүхнийг биелүүлээд байвал мөнгөний үнэ цэнэ тэдний хувьд юу болж хувирах бол. Харин этэд гэр бүлийн хувьд хүүхдүүдийнхээ хэн нэгэнд ямар нэг зүйл авч өгөх бол ээж, аавынхаа өдөр бүр өгдөг хэрэглээний мөнгөнөөс хэмнэж, илүүчилсэн бол нэмж, авч өгнө гэсэн шаардлага тавьдаг. Багадаа 10, 20 мөнгө цуглуулж дуртай зүйлээ авдаг байсан гэрийн эзэгтэй багын хүмүүжлээ хүүхдүүддээ уламжилж буй нь энэ. Өдийг хүртэл хүүхдүүдээ нэг ч удаа өлсгөж даарууулж үзээгүй ээж, аав нь “Яваандаа нэг хоосон хонуулж үзэх л хэрэгтэй юм байна” гэж хэлж байлаа. Энэ бол тэднийг амьдралд юу ч тохиолдсон даваад гарах тэсвэр хатуужилтай байгаасай гэж хүссэн эцэг эхийн сэтгэл.

Тэдний сэтгэл, зүтгэлээ зориулсан хөрөнгө оруулалт насан туршийн шавхагдашгүй хөрөнгө болон хувирах биз ээ.

Монголын ухаалаг үрс маш олон болтугай! ■



ШИЛДЭГ ИЛТГЭЛ

ЧАНАРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ӨЗҮҮЛЭХ НЬ КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА ЮМ



ДР. МИХАЕЛ БЮРШ
/Германы компанийн засаглалын төвийн удирдах зөвлөлийн гишүүн/

Дэлхийн өнцөг булан бүрт КНХ-ын тухай ойлголтыг өөр өөрөөр нэрлэдэг. Нэгдсэн нэг ойлголт байдаггүй гэсэн үг. Улс орон, бүс нутаг болон бизнесийн салбар тус бүр тухайн бизнес нь нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж, ямар эрх эдлэх ёстой болохоо өөрсдөө тодорхойлох ёстой. Нийтлэг хэд хэдэн зарчим байдаг. Тухайлбал, шударга хөдөлмөрийн стандарт, байгальд үзүүлэх үр нөлөө, салбар хоорондын хамтын ажиллагаа, мөн дэлхий дахины том асуудал болох авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэх, тунгалаг байх, хувьцаа эзэмшигчдийн хүлээх санхүүгийн хариуцлага гэх мэт нь гол хамрах хүрээ юм.

Дараагийн үзэл баримтлал нь улстөрчийн үүднээс харахад /Др. Михаел Бюрш Германы Парламентын гишүүнээр 12 жил ажиллажээ/ өнөөгийн эдийн засаг, байгаль экологи ба нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд төр, засаг, бизнесийн болон боловсролын байгууллагууд, ард иргэд мэдлэг оюун ухаан, ур чадвараа нэгтгэн, шинийг санаачлагч хариуцлагатай бүх хүчийг нэгэн ширээний ард цуглуулах замаар хамтын хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. "Бид хэдийнэ түншлэлийн эринд хөл тавьцгаасан" гэж Саймон Задек нэг удаа хэлсэн билээ.

Төр, засгийн гүйцэтгэх үүрэг

Засгийн газар бизнесийн салбарынхантай хамтарч ажиллах шаардлагатай. Хэдийгээр өнөөдөр Германд салбар хоорондын хамтын ажиллагаан дээр туршлага багагүй хуримтлуулсан ч маш их сөргөлдөөнтэй тулгардаг. Тухайлбал, Засгийн газар болоод иргэний нийгэм, бизнесийн салбарынхан хэл амаа ололцохгүй байх тохиолдол их гардаг. Бид орчин үед хоорондоо эсрэгцэлдэн тулж ажиллахын оронд хамтран ажиллах эрин үед ирээд байна гэдгийг хэлье. Төр, засгийн гүйцэтгэх үүргээс хамаарч КНХ нь улс төрийн асуудал болжээ.

Өнөөгийн төр, засгийн тухайлбал, Германы Засгийн газрын үүрэг, хариуцлагын хүрээ нь зөвхөн зах зээл болон компаниудын хууль эрх зүйн хүрээг тогтоох, дэд бүтэц, нийгмийн эд баялгийг дахин хуваарилах зэргээр хязгаарлагдахаа больжээ. Төр, засгийн хийх гол ажил КНХ-тай холбоотой үндэсний стратегийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх, хариуцлагатай компанийг урамшуулах, олон хувьцаа эзэмшигчдийн уулзалт, хэлэлцээрийг дэмжих, өөрсдийн байгууллагын хариуцлагын бодлого хөтөлбөрийг боловсруулахад оршино.

Иргэний нийгмийн гүйцэтгэх гэрээнд төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа тэд компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг тодорхойлдог гэж хэлж болно. Тухайлбал, уул уурхайн компани орон нутагт ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг дээр ч юм уу. Германд гурван сая хүн "Өөрөө өөртөө туслах" хөдөлгөөнд оролцдог. Энэ нь нийгмийн хариуцлагын систем бусад бодлогод дагалдаад явдаг гэсэн үг юм.

Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа ТББ-ууд олон нийтийн хөгжлийн чиглэлээр идэвхтэн, хяналт тавигч, мөн түншлэгчийн үүрэг гүйцэтгэдэг тул КНХ-ын бодлогыг тодорхойлдог. Мөн давуу тал багатай гишүүдийг дэмжих байдлаар олон нийтэд үйлчлэх, хамтын ажиллагаанд сайн дураар оролцох, өөрөө өөртөө туслах замаар олон нийтэд эрх мэдэл олгож ажилладаг.

Бизнесийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг

Компаниуд өнөөдөр хууль эрх зүйн хүрээнд зөвхөн татвараа төлөхөөс өөр хариуцлагагүй болсон байна. Гэтэл өнөөдөр хамтын ажиллагаа ялангуяа нийгмийн хариуцлагатай хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болжээ. Хариуцлагатай компанийг урамшуулах, үндэсний стратегийн асуудлыг хамтран боловсруулах нь чухал юм. Засгийн газрын зүгээс хариуцлагатай компаниудыг тодорхой хэмжээгээр урамшуулах хэрэгтэй. Өнөө үед бизнесийн салбарын үүрэг маш өндөр болсон. Компаниуд хуулийн хүрээнд татвараа төлөөд, ашгаа хийгээд явахаас гадна бусдыг ивээн тэтгэх, буяны үйл ажиллагаа явуулах байр сууриа өөрчилж, нийгмийн болоод байгаль орчны асуудлыг идэвхтэйгээр шийдвэрлэдэг болж эхэлж байна. Энэ бол маш сайн зүйл. Нийгмийн сайн сайхны төлөө чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх нь компанийн хариуцлага болж байна. ■

DISCOVER MONGOLIA

СОНГУУЛИЙН ЭДИЙН ЗАСАГ

Б.БАЯРТОГТОХ

“Уул уурхайн баялгаа эцсийн бүтээгдэхүүн болгох боловсруулах үйлдвэрийн асуудлыг шуурхайлж, төмөр зам тавих ажлаа яаравчилсан бол намуудад нэг санал ч болтугай нэмэгдэх байсан”



ОлонхийнсаналаарбүгдийгшийддэгПарламентийн засаглалтай манай оронд уул уурхайн хөрөнгө оруулалт сонгуулийн амлалтаас шууд хамаардаг болчихов. Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг намын мөрийн хөтөлбөрөөр дэгээдэж унагадаг удамшил сүүлийн жилүүдэд бүр ч гаарсаар. Урьд өмнө нь хэзээ ч харагдаж байгаагүй уул уурхайн мөнгөөр зах зээлийг, нийгмийн оюун санааг их хүлээлтээр эвдэж чадсан 2008 оны сонгууль үүний тод жишээ юм. Манай улс уул уурхайн баялгаар өрнийг орхиж, дорныг гүйцэн түрүүлж явна.

Харин өрсөлдөх чадвараараа нэлээд хойно орно. Тодруулбал, 2011-2012 оны тайлангаар 3.9 оноогоор 142 орноос 96 дугаар байрт оржээ. Өмнө нь 3.7 оноогоор 99 дүгээр байрт жагсаж байсан Монгол Улс нэг жилийн дотор гурван байраар урагшилжээ. Монгол Улсын өрсөлдөх чадвараар ахих энэхүү үзүүлэлтэд уул уурхайн хөрөнгө оруулалт амь тариа болжээ. Үүнээс ч урагш байрт жагсах боломж байсныг учир мэдэх зарим хүн хэлж байна. Төсвийн байдал сайжирч, ДНБ-д эзлэх гадаад өрийн хэмжээ буурсан нь манай улсын зэрэг зиндааг хөгжиж байгаа орноос хөгжингүй орны стратегийн түвшинд аваачсан байна. Энэ хэрээр монголчуудын үнэлэмж дэлхий нийтэд өсчээ.

Зах зээлийн замаар урагшаа нүүр бардам харах өргөн боломж Тавантолгой төслөөс харагдаж буй. Говьд тодорч илрээгүй олон “толгой” бий гэдэгт ч гаднынхан эргэлзэхгүй байна. Тэгвэл баялгийн шимээр сольж буй хөрөнгийг сонгуулийн амлалтаар урсгаад байх уу. Уг нь улс төрийн хүчин үр ашигтай бодлого ярьдаг болохоос мөнгө амладаггүй. Тиймээс эдийн засгийн тэнхлэг болсон гол салбар уул уурхайн хөрөнгө оруулалтыг сонгуулийн амлалттай хутгах бус, цэвэр орлого гэж харах цаг болжээ. Баялгийн өгөөжийг сулруулдаг мөнөөх сонгууль хаяанд ирчихсэн. Улстөржиж болохгүй мөнхийн сэдэв эдийн засаг болов чиг энэ удаад улс төрийн үйлдлээс уул уурхайн хөрөнгө оруулалтыг ялгаж салгах хэрэгтэй боллоо. Улс төрийн нөлөөнд үл автах хүчирхэг эдийн засагтай болоход сонгууль том шалгуур аж. Гэхдээ газрын хэвлийд буй баялаг бүх ард түмний өмч болохоос нам, хэсэг бүлэг хүмүүсийн “санхүүжилт” биш юм.



Шавхагдах баялгаар шавхагдашгүй баялаг бүтээе

Парламентийн болон орон нутгийн сонгууль манай эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлдэг болсоор удаж байна. Өнөөдөр ч гэсэн сонгууль хаяанд ирсэнтэй холбоотой аль ч салбарт харзнасан ажигласан байдал нийгэмд бий боллоо. Тэр дундаа бүтээн байгуулалт, хөгжил далласан уул уурхайн салбарынхны ажлын хурд саарч, “Сонгууль яах нь вэ” гэсэн хүлээлт бий болчихоод байна. Монгол Улсын эдийн засгийн төвлөрөх цэг нь улс төрийн сонгууль гэж үү. “Өнгөрсөн оны төсвийг 10 хувийн алдагдалтайгаар баталж, 805 тэрбум төгрөгийг хүн амд тараасаар Монгол Улс бүхэлдээ “Сонгуулийн эдийн засагтай болсон” гэж МУИС-ийн ЭЗС-ийн дэд профессор Б.Батмөнх хэллээ. Тэрбээр “Монгол Улс: Шилжилтийн эдийн засгаас сонгуулийн эдийн засагт” өгүүлэлдээ “Монголын эдийн засаг хэт улстөржсөн, жам ёсоороо хөгжих нөхцөл муутай болсон. Эдийн засагт сонгуультай холбоотой мөнгөний эргэлт их болжээ” хэмээн дүгнэсэн байна. Улс төрийн намууд нь засгийн эрхэнд гарахын тулд сонгогчдод эдийн засгийн хэр хэмжээнээсээ хэтэрсэн амлалт өгч гарч ирдэг. Намуудын сонгуулийн амлалт нь буцаад эдийн засагтаа маш хүчтэй дарамт үзүүлдэг болсон. Улс төрийн намууд сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэхийн төлөө эдийн засгаа золиослоход ч бэлэн гэдгээ тод томруун харуулсан хэмээн цөөнгүй эдийн засагчид ярьсан юм. Тэд үүнийг эдийн засгийн тамирдалт гэж нэрлээд байна.

ДНБ-д төсвийн зардал 2005 онд 27 хувийг эзэлж байсан бол өнгөрсөн онд 52 хувь болжээ. Ирээдүйд их итгэл өвөртөлсөн намууд ар түмнээс зүтгэл гуйж, бодит байдлыг ярихаас цааш хэтрээгүй улстөрчид уул уурхайн салбарын хөгжлийг тушаатай үлдээх нь гэсэн халаглал хөрөнгө оруулагчдыг хамгийн ихээр бухимдуулж байна. Төв Азийн цээжинд судлагдаагүй үлдсэн, судлагдсан өчүүхэн хэсэг нь дэлхийн хөрөнгө оруулагчдын “хорхой”-г хүргэсэн Монгол урин хавартай золголоо. Ирэх сонгуулийн дуулиан, шуугиан Төрийн ордонд цуурайтсаар. “ДНБ-ийхээ 10 хувийг хүн амдаа зүгээр тараадаг эдийн засагтай улс дэлхийд Монголоос өөр байхгүй. Үүгээрээ Монгол Улс дэлхийд цоо шинэ өвөрмөц “сонгуулийн” эдийн засгийг бүтээж байна” гэж ОУВС, Дэлхийн банк цочирдож байв.

“Уул уурхайн хөрөнгө оруулалтыг Хүний хөгжлийн 21 мянга, цалин тэтгэврийн нэмэгдэл, оюутны сургалтын төлбөр гэж ангилсан нь хөрөнгө оруулалтын хүчийг сулруулж, үр ашиг муутай, үлдэх үнэ цэнийг нь бууруулсан” гэж Эрдэс баялгийн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Х.Владимир хэлсэн. Зэсэн төсөвтэй Монгол Улс цаашид нүүрсээр төсвөө зохиож, нүүрсний орлогоороо нэг удаагийн сонгуулиа нэжгэр тэмдэглэж, үлдсэн хугацаанд нь амлалтаа төлж амьдрах уу.

Статистик мэдээллээс үзэхэд экспортын 98 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлжээ. Гэтэл экспортолсон нүүрснийхээ дайтай бүтээн байгуулалтыг өрнүүлж чадаагүй л байна. Тиймээс шавхагдах баялгаар шавхагдашгүй баялаг бүтээе. “Уул уурхайн баялгаа эцсийн бүтээгдэхүүн болгох боловсруулах үйлдвэрийн асуудлыг шуурхайлж, төмөр зам тавих ажлаа яаравчилсан бол намуудад нэг санал ч болтугай нэмэгдэх байсан” гэж академич Т.Намжим ярьж байна.

Уул уурхай эдийн засгийн тэргүүлэгч салбар мөн үү

Намын мөрийн хөтөлбөрт бөөн бөөнөөрөө базагдаж орж байгаа хөрөнгө оруулалт бол улс төрийн намын бий болгосон бүтээмж бус, буй болсон байгалийн шавхагдах баялаг. Өнгөрсөн хугацаанд улс төрийн намууд сонгуулийн амлалтаа иргэддээ төлөхийн тулд ажилласан. Амлалтаа хэрэгжүүлэхийн хэрээр

эсрэг талд нь баялгийн сав дундарчээ. Түүнээс улс төрийн намууд зөв бодлого хэрэгжүүлээд үйлдвэрлэлийн салбараа сэвхийтэл дэмжсэн зүйл огтхон ч алга. Нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүний төрөлжилт өнгөрсөн хугацаанд дорвитой өссөнгүй. Зүгээр л уул уурхайн баялгаар сонгуулийн амлалтаа биелүүлэхийн тулд Монгол Улс дэлхийн зах зээлийн үнээс хэд дахин хямдаар баялгаа үнэлжээ. “Тамирын мөсийг долоох шахам байж олсон хэдээ гэх..” Итгэлт баяны бодол улстөрчдөд дутсан аж. Зөвхөн хуваарилах зохицуулалтыг өнгөрсөн хугацаанд намууд амжилттай гүйцэтгэсэн тухай эдийн засагчид хэлдэг. АХБ-ны “Азийн хөгжлийн төлөв-2012” тайланд Монгол Улсын ДНБ-ий өсөлт энэ онд 15, ирэх жил 17.5 хувьд хүрнэ гэж тооцоолжээ. Энэхүү эдийн засгийн эрчимтэй өсөлт нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг шаардаж байгаа гэж Азийн хөгжлийн банкны эдийн засагч Л.Амар тэмдэглэсэн.

Өнгөрсөн хугацаанд уул уурхайн салбар өргөжиж, зах зээлийн хүрээгээ тэлэхийн хэрээр улс төрийн намуудын сонгуулийн амлалт томорсон. Төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр зарлагад “сонгуулийн амлалт” ахиу жин дарах болжээ. Уг нь зэс, нүүрс, төмрийн хүдэр, жонш гээд шавхагдах нөөцөөрөө олж авсан хөрөнгөөр шавхагдашгүй баялаг бүтээхийг дэлхий нийт эрмэлзэж, түүндээ хүрэхийн төлөө хичээж байна. “Уул уурхай эдийн засгийн тэргүүлэгч салбар болохоос улстөрчдийн сонгуулийн амлалт биш. Тиймээс эдийн засгийн өсөлт бол улс төрөөс үл хамаарсан, эрэлт нийлүүлэлтээр хэмжигдэж байдаг тоо” гэж СЭЗДС-ийн багш Ц.Батсүх ярьсан юм.

Өөрөөр хэлбэл, одоогийн эдийн засгийн өсөлт бол уул уурхайн баялгаа ямар ч боловсруулалтгүйгээр эрчимтэйгээр гадаад зах зээлд нийлүүлсний үр дүн гэж үзэж болох аж. “Уул уурхайн хөрөнгө оруулалтаар юу эсийг бүтээх билээ. Зөвхөн сонгуулийн амлалт төдийхэн зүйлийг л бүтээхийн төлөө Тавантолгойг таллаж, эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага байна уу” гэж Дундговь аймгийн Сайнцагаан сумын малчин Б.Адьяа Монголын эдийн засгийн чуулганы үеэр төрийн төлөөллөөс асуулаа. Гэтэл Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай дэд бүтэц, усны асуудал “түүхий” хэвээрээ байна. Тэгвэл хариуцлагатай уул уурхайн хөгжлийг хариуцлагагүй засаглал бүтээж чадах болов уу. Ачааны хүндийг үүрч яваа уул уурхайн салбарынхан болоод татвар төлөгчдийн үүрэг оролцоо, үр ашиг улс төрийн үзэмжээс болоод бүдгэрч байгааг салбарынхан ч хэлдэг.

Ялалт, ялагдлын ринг

Уул уурхайн салбарынхан болоод улстөрчид хамтдаа ялалт, ялагдлын ринг дээр зогсож байна. Баялгийн буянаар эрх мэдэл олдог, улс төрд урт удаан амьдрах байр сууриа ч баталгаажуулдаг сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс уул уурхайг тусгаарлая. Олохыг нь уурхайчин олж, улстөрчид олсныг нь үрдэг тогтолцоо сайныг дагуулахгүй гашуун сургамж баялгаасаа болж баларсан орнуудад бий. Ангол, Нигер, Судан, Конго гээд тэдний жишээг тив дэлхийгээрээ мэднэ. Хөрөнгө оруулалтын үнэ цэнийг унагах болсон сонгуулийн амлалт манайд хэвээр байвал үсрэнгүй өсөлт гэнэтийн уналтаар солигдож мэдэхийг Дэлхийн банкны судлаачид сануулж байна. Улс төрийн намууд хэдий чинээ өндөр амлалт хэлнэ төдий чинээ уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үр ашиг багатай 21 мянга болон хувирч байгааг Монголбанкны эдийн засагч С.Болд хэллээ. АН-ын дарга Н.Алтанхуяг “Эдийн засгийн хувьсгал эхэллээ” гэсэн илтгэлдээ “Бэлэнчлэх сэтгэлгээ газар авч, баян ядуугийн ялгаа холдож байна. Хүний насжилт, боловсролын түвшин доогуур байна. Энэ бүхэн бол манай эдийн засгийн согог юм” гэв. Тэрбээр ийн ярьж хэлж буйгаа намынхаа мөрийн хөтөлбөртөө баримталж, жанжин шугамаа болговол сайн л байна. Намуудын сонгуулийн амлалт том тоогоор сонсогдох бүрийд амьдралын өртөг, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсчээ. Амлалтаа нэхсэн иргэд, амлалтаа биелүүлэхийн төлөө юугаа ч зарж мэдэх бодлогогүй төр өөд өөдөөс харцгаана. Нийгмийн зорилтод хэсэгт хандсан дэмжлэг бүхэл бүтэн нийгмийг хамарсан сонгуулийн “лоозон” болов.

Олборлолт эхлээгүй, зөвхөн хайгуулын шатандаа яваа геологи уул уурхайн компани өөрийн өртгийн 10 хүртэлх хувийг ажлаа бүтээх, бүтээлгэх зүйлд зориулдаг гэсэн баримтыг уул уурхайн хүмүүс сонирхуулах нь бий. Тэгвэл уул уурхайн салбарын өгөө аваа улстөрчдийг дэмждэг болж таарч байна. Тэтгүүлж дэмжүүлэхийг улстөрчид болоод намууд шаарддаг юм байна. Баялгаа үнэд хүргэхийн төлөө төр нь дэмждэг болохоос түүний үнэ цэнийг сонгуулийн амлалтаар дэгээдэж унагадаг жишиг зөвхөн Монголд тогтож таарахгүй. ■



Эх сурвалж: Монголын эдийн засгийн форум

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛ НҮҮРСНИЙ БАЯЛГАА “НОГООН” НҮҮРС БОЛГОХ БОЛОМЖТОЙ

Нүүрсний арвин их нөөц, газар зүйн байршил зэрэг нь олон улсын хэмжээний нүүрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний эх үүсвэрийн хөгжлийг нийгмийн хариуцлагатай хослуулсан дэлхийн сайн жишиг болох боломжийг Монгол Улсад олгож байна.



АРШАД САИЕД /“Пийбоди Энержи” компанийн монгол, энэтхэгийг хариуцсан ерөнхийлөгч/

Монголын эдийн засгийн чуулганд дахин оролцох завшаан миний биед тохиосон юм.

Саяхан болж өнгөрсөн уг чуулганаар Монгол Улсын хөгжлийн хувьд ихээхэн чухал олон асуудлыг хэлэлцсэний дотор хоёр сэдэв анхаарлыг минь ихээхэн татсан билээ. Эдгээр нь Монгол Улсын эдийн засгийг хэрхэн ногоон болгох мөн тус улсын эрчим хүчний салбарын өрсөлдөх чадварыг улс орны хөгжил хийгээд ард олны сайн сайхны төлөө хэрхэн дээшлүүлэх тухай байв.

Чуулганд оролцогчид нүүрс болон эрчим хүчний бусад эх үүсвэрээр арвин баялаг Монгол орон хэтдээ “Эрчим хүчний диваажин” болох боломж байгаа тухай онцлон ярьж байлаа. Үүнийг бодит ажил болгоход дэлхийн хэмжээний томоохон компаниуд тус улсын эрчим хүчний салбарын цаашдын хөгжилд гар бие оролцох сайхан боломж бий болж байна. Дэлхийн хэмжээний компаниуд аюулгүй ажиллагаа, нийгмийн хариуцлага, байгаль орчны хамгаалал, технологийн шийдэл зэргээр Монгол Улсыг олон улсын хэмжээнд сайн жишиг улс болгоход ихээхэн хүчин чармайлт гарган, үр дүнд хүргэх чадвартай.

“Пийбоди Энержи” компани Монголын эдийн засгийн чуулганд энэ жил дахин оролцсондоо баяртай байна. Энэхүү чуулга уулзалтын цар хүрээ улам бүр тэлж, Монголын эдийн засгийн нэг тулгуур багана болох уул уурхайн салбарын өсөлтийн тоон үзүүлэлтүүдийг чанарын хувьд сайжруулахад ихээхэн тустай хэлэлцүүлгүүд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийнхний дунд боллоо.

Дэлхийн томоохон уул уурхайн компаниуд Монголын ашигт малт-малын салбарт олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлж, нутагшуулах онцгой боломжтой бөгөөд энэ хүрээнд Монголын Засгийн газар, бодлого тодорхойлогчидтой нягт хамтран Монгол Улсын нүүрсний үйлдвэрлэлийг эрчим хүчний жинхэнэ “диваажин” болгохын төлөө ажиллах үүрэгтэй.

Чуулганд оролцогчид Монгол Улсын хувьд нүүрс цаашдаа улам бүр өсөн нэмэгдэх эрчим хүчний хамгийн боломжит, найдвартай эх үүсвэр бөгөөд нийгэм эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч чухал хүчин зүйл байсаар байх болно гэсэн нэгдсэн ойлголттой байв. Үнэхээр ч нүүрс эдийн засгийн эрчимтэй өсөлтийг эрчим хүчээр хангахын зэрэгцээ ард түмний амьжиргааны түвшнийг дээшлүүлэх чухал эх үүсвэр юм.

Нүүрсний хэрэглээ болон эдийн засгийн өсөлтийн хооронд шууд уялдаа хамааралтай байдаг. Энэхүү хамаарлыг нүүрсний хэрэглээ өсөхөд дотоодын нийт бүтээгдэхүүн мөн өсдөг байдлаас илхэнээ харж болно. Хятад улс дэлхийн хамгийн хурдтай хөгжиж буй эдийн засагтай орон. Хятад эрчим хүчний хэрэглээ болон нүүрсний нийт хэрэглээгээрээ дэлхийд тэргүүлж байгаа нь тохиолдлын хэрэг биш юм.

Тус улсын ДНБ ирэх 20 жилд 275 хувиар өсөх бөгөөд мөн хугацаанд нүүрсний хэрэглээнь үлэмжнэмэгдэнэ гэсэн тооцоолол бий. Үүнтэй адил Монголын эдийн засаг хурдацтай өсөх хэрээр асар их хэмжээний эрчим хүч шаардагдах болно. Өсөн нэмэгдэх энэхүү хэрэгцээг хамгийн боломжит бага өртгөөр хангаж чадахуйц эх үүсвэрүүдийн нэг нь яах аргагүй нүүрс мөн. Ингэснээр эрчим хүчний хангамжийг орлогын ялгаатай байдлаас үл хамааран бүх иргэдэд ижил тэгш хүргэж, улмаар нэмэгдүүлэх боломжтой.



Сүүлийн жилүүдэд маш ихээр өсч байгаа нүүрсний экспорт Монголын эдийн засагт ихээхэн үр өгөөжийг авчрах нь тодорхой. 2008 онд 9.8 сая тонн байсан нүүрсний олборлолт 2011 онд 30.9 сая тонн болж өссөн бол 2020 онд 100 сая тонн нүүрс олборлох төлөвтэй байна.

Монголын эдийн засгийн чуулганаар хүрэн эдийн засгийг ногоон эдийн засаг болгох арга замуудын талаар нухацтай хэлэлцүүлгүүд өрнөсөн. “Пийбоди Энержи” Монгол Улсад хамгийн дэвшилт технологид суурилсан, нүүрснээс гарах хорт ялгаралтыг бараг бүрмөсөн тэглэх “ногоон нүүрсний” үйл ажиллагааг хэрэгжүүлж, ингэснээр тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна хэмээн төлөвлөж байна.

Манай компани нүүрснээс гарах ялгаралтыг бууруулах, карбоныг багасгах төслүүдийг АНУ, БНХАУ, Австрали зэрэг оронд эрчимтэй хэрэгжүүлж буй билээ. БНХАУ-д хэрэгжиж буй 650 МВт хүчин чадалтай цахилгаан станц, карбон судалгааны төвөөс бүрдэх “Грийнжен” төсөлд хөрөнгө нийлүүлэгч цорын ганц гадаад түнш нь “Пийбоди Энержи” юм. Өнөөдөр энэ төсөл туршилт хийх, мөн 250 МВт хүчин чадал бүхий эхний ээлжээ ашиглалтад оруулах шатандаа явж байгаа бөгөөд бүрэн дууссан цагтаа карбон ялган хураах мөн шингэн түлш боловсруулах технологи бүхий цогцолбор болох юм. Энэ төсөл амжилттай хэрэгжсэнээр ялгаралтыг бараг бүрмөсөн тэглэж чадсан бүрэн хүчин чадлаар ажиллах, дэлхийн хамгийн том дулааны цахилгаан станц (нүүрсний) болно. Эдгээр технологиуд нь нүүрсэнд суурилсан эрчим хүчний үйлдвэрлэлд эргэлт гаргаж, тогтвортой хөгжлийн ирээдүйг тодорхойлж чадна.

Нүүрсний олборлолт, түүний хэрэглээ ер нь нүүрс үйлдвэрлэлтийн бүхий л шатанд байгаль хамгааллын хамгийн шилдэг арга барилуудыг нэвтрүүлж, бодит үр дүнд хүрэх нь компанийн тэргүүн зорилго хэмээн “Пийбоди Энержи” үздэг. Манай компани Монгол Улс дахь нүүрсний уурхайн анхны цогц нөхөн сэргээлтийг Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Эрээний нүүрсний уурхайд хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн үр дүнд нүүрсний уурхай байсан газар хөрш зэргэлдээх газраас дөрөв дахин илүү өвсний гарцтай бэлчээрийн нутаг болсон. Энэхүү төслийг бид Байгаль орчин, аялал жуулчлалын яам, холбогдох бусад байгууллага, их дээд сургуулиуд болон төслийн багт ажилласан инженерүүдтэй хамтран хэрэгжүүлсэн.

Бид уг нөхөн сэргээлтийг хийхдээ байгаль хамгааллын тал дээр дэлхийн хэмжээнд хуримтлуулсан тэргүүн туршлагаа ашиглахын зэрэгцээ тухайн газар нутагт Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран хийсэн судалгаанд тулгуурласан билээ. Уул уурхайн нөхөн сэргээлтийн шилдэг технологи, мэдлэгээ Монголд шилжүүлэх нэвтрүүлэх энэхүү оролдлого нь газрын нөхөн сэргээлтийн талаарх үндэстний мэрэгжилтнүүд болон орон нутгийн хүмүүсийн мэдлэг, туршлага, арга барилд хувь нэмэр оруулсан гэдэгт бид итгэлтэй байна.

Дэвшилт технологийг нэвтрүүлэх нь уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйл нь юм. “Пийбоди Энержи” нь өөрийн уурхайн ажиллагсад, тухайн нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн өртөг зардал бага, мөн карбон багатай эрчим хүч үйлдвэрлэх хамгийн оновчтой шийдлүүдийг нэвтрүүлж, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлдгээрээ дэлхийн тэргүүлэгч компани билээ.

Бид байгалийн баялгаа эдийн засгийн эргэлтэд үр ашигтайгаар оруулахыг зорьж буй Монгол Улсад дэмжлэг үзүүлэгч түнш нь болж буйдаа туйлын бахархалтай мөн хариуцлагатай хандаж байгаа билээ. Цэвэр, ногоон нүүрсний ирээдүйг ойртуулахын тулд аюулгүй ажиллагаа, уурхайн үндсэн үйл ажиллагаа, байгаль хамгаалал болон нийгмийн хариуцлагын чиглэлээр өөрийн эзэмшсэн тэргүүн туршлагуудаа Монголд зохистойгоор нэвтрүүлэх тал дээр цуцалтгүй ажиллах шаардлагатай байна гэдгийг ойлгож байна. Бидний энэ үзэл баримтлал үеийн үед үр өгөөжөө өгөх эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг монгол ёстой яв цав нийцэх учиртай.

Нүүрсний арвин их нөөц, газар зүйн байршил зэрэг нь олон улсын хэмжээний нүүрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний эх үүсвэрийн хөгжлийг нийгмийн хариуцлагатай хослуулсан дэлхийн сайн жишиг болох боломжийг Монгол Улсад олгож байна. Хамтдаа бид энэ эрхэм зорилгод хүрч чадах бөгөөд ингэсэн цагт эрчим хүчний диваажин болох нь лавтай. ■

ОЮУТОЛГОЙН БУЛАН

БУЦАЛЖ БУЙ ХАНБОГД

XXI зууныг “лаатай” угтсан Ханбогд сумыг байнгын эрчим хүчээр хангах цахилгаан дамжуулах шугамын ажилд зургаан тэрбум гаруй төгрөгийн барилга угсралтын ажлыг үндэсний аж ахуйн нэгжүүд гүйцэтгээд эхэлжээ.

Ханбогдын нуруунд хаврын цас тогтохгүй. Тогтлоо гээд долоо ч хонохгүй хайлна. Говь нутгийн ааш нэг ийм. Тэнгэрээс унаж буй цас нь хүртэл бороо шиг хөрсөндөө бууна. Мэлмэрч, мэлтийх нуур говьд харагдахгүй ч, урьд цагт далай байсан шинжээ говь нутаг гээхгүй. Торго шиг элстэй. Агь хөмүүл, таанын үнэр хамар цоргисон бүлээн салхитай Өмнийн говь. Өдөөс дулаан илчээр төөнөх нь нутгийн төрх. Зулай дээрээс зуух мэт халах нар. Нууцад нь үл нэвтэрч болох говийн суунагар хөх дайвалзсан зэрэглээ. Тив дэлхийд цөөн үлдсэн тэмээн сүрэг. Нар, салхи, халуун, хүйтний дайралтыг няцааж ирсэн заг мод.

Цуутай ган зудыг туулсан хашир малчин өвгөд. Олны хөлд үрэгдэж зутраагүй онгон догшин хулан, тахь, хавтгай, мазаалай. Хот сууринг зорин нутгаа орхиж нүүгээгүй говийн зон олон. Дэлхийд Монголын нэрийг дэлдийлгэж яваа Оюутолгой орд. Энэ бүхэн Ханбогдыг бүтээж буй хэрэг. Ханбогд гэх энэ нэрийг одоо мэдэхгүй хүн бараг үгүй биз. Цаг агаарын мэдээнд Ханбогд сумын нэр тогтмол урсаж өнгөрдөг. Хээзэний танил нэртэй говийн сууринд уул уурхайн үр шимээр бүтээн байгуулалт дагасан хөгжлийн үнэр ханхалж байна.



Монголын хамгийн халуун газар, эдийн засаг, улс төрийн онцгой талбар болсон Ханбогдоос хөгжлийн зүтгүүр хөдөлжээ. Тус суманд амьдрал буцалж байна. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга Б.Дэндэвсамба “Бүтээн байгуулалт ихсэж, ажлын байр нэмэгдэхийн хэрээр шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байна” гэж хэллээ. Ханбогдод хаврын сар бус, зуны сар үргэлжилсэн мэт дулаахан. Саяхан Ханбогд сумын төвд таван га газарт мод үржүүлгийн газрыг “Оюутолгой” компаниас байгуулсан гэж дууллаа. Тодруулбал, Мод үржүүлгийн газар. Уг талбайд уурхайн талбайн нөхөн сэргээлтэд ашиглах олон наст ургамлууд ургуулах, үржүүлэх, ховор ургамлуудыг тарималжуулах талбай болох гэнэ. Ханбогдод цэцэрлэгт ногоон байгууламж, мод бут тун ховор. Хөгжлийг даллах эрчим хүчний асуудлаа ч говийнхон шийдэж байгаа юм байна. XXI зууныг “лаатай” угтсан Ханбогд сумыг байнгын эрчим хүчээр хангах цахилгаан дамжуулах шугамын ажилд зургаан тэрбум гаруй төгрөгийн барилга угсралтын ажлыг үндэсний аж ахуйн нэгжүүд гүйцэтгээд эхэлжээ. “Оюу Толгой” ХХК-ийн Бүс нутгийн хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн дэд ерөнхийлөгч Т.Баярсайхан “Бид өнгөрсөн гурван жилийн хугацаанд Өмнөговь аймгийн соёл, эдийн засаг, нийгмийн хөгжилд зориулан 30 гаруй тэрбум төгрөгийн хандив, тусламжийг үзүүлсэн” гэв. “Оюу Толгой” компани ажиллах хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн гурван төвийг шинээр барьж, дөрвийг нь шинэчлэн сайжруулжээ.

Манай улсын түүхэнд хамгийн том санхүүжилт буюу 110 тэрбум төгрөгийг зарцуулах Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн нэг нь Ханбогдод бий. Энэхүү сургалтын төв ирэх зун нээлтээ хийхээр зэхэж байна. Мөн орон нутгийн 72 иргэнийг англи хэлний мэдлэгээ сайжруулах хөтөлбөрт хамруулжээ. Тэд сургалтын хугацаанд англи хэлний мэдлэгээ сайжруулан, ажилд ороход өөрийгөө хэрхэн бэлтгэх, шаардлагатай баримт бичгүүдийг зөв боловсруулах, мөн ажил олгогчдын ярилцлагад хэрхэн амжилттай оролцох зэрэг тал бүрийн мэдлэгтэй болсон байна. Говь нутагт гэгээрлийн ажил өрнөсөөр. Одоогийн байдлаар Өмнөговь аймгийн нутагт хэрэгжиж буй дэд бүтцийн 12 төслийг үндэсний аж ахуйн нэгж, компаниуд гүйцэтгээд байгаа аж.

“Оюу Толгой” ХХК-ийн Үндэсний худалдан авалтын хөгжлийн хэлтсийн менежер Б.Сэржмаа “Жижиг, дунд бизнес эрхлэгч, шинэ аж ахуйн нэгжүүдийг бизнесээ өргөжүүлэхэд нь туслах, санхүүгийн эх үүсвэр олох асуудлыг нь шийдэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор бичил зээлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрийн зээлийн санг 1,5 тэрбум төгрөгөөр бүрдүүлэн Хас, ХААН банкинд байршуулан хөнгөлөлттэй зээлийг Өмнөговийн бизнесмэнүүдэд олгож байна. Одоогоор орон нутгийн 50 гаруй жижиг, дунд бизнесийнхэн зээл авч, үйл ажиллагаагаа эхэлж, өргөжүүлэн хөгжүүлж байна” гэж ярьсан. Орон нутгийн тогтвортой хөгжил эндээс л эхлэх буй за.

Ханбогд сумын хажууханд Оюутолгой орд бий. Дэлхий дахинаа зэсийн ханш он гарсаар эхний улиралд 12 хувиар нэмэгдээд байна. Энэ нь дэлхийн зэсийн 40 хувийг дангаар олборлодог БНХАУ бодлогын хүүгээ чангалсантай холбоотой аж. “Bloomberg” агентлагийн мэдээлж буйгаар “Дэлхийн зэсийн зах зээл тун удахгүй Монголоос хамааралтай болох бөгөөд энэ нь 2012 оны гуравдугаар улирлаас эхлэн ашиглалтад орох Оюутолгойн уурхайгаас шалтгаална” гэж үзжээ. ■

ТООН МЭДЭЭ

Оюу Толгойн талаар тоо баримтууд

7.8 их наяд гаруй төгрөг (зургаан тэрбум ам.доллар) – 2013 онд Оюу Толгой уурхай ашиглалтад орохоос өмнө хийх хөрөнгө оруулалтын хэмжээ.

4.5 триллион буюу их наяд төгрөг (3.5 тэрбум ам.доллар) – 2011 оны эцэс гэхэд Оюу Толгой төсөлд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ.

320 тэрбум төгрөг (250 сая ам.доллар) Оюу Толгойн хөрөнгө оруулагчдаас Монголын Засгийн газарт одоогийн байдлаар төлөөд байгаа ашгийн татварын хэмжээ.

900 тэрбум төгрөг (700 сая ам.доллар) Оюу Толгойн хөрөнгө оруулагчдаас уурхай ашиглагдахаас өмнө улсын төсөвт оруулах татварын хэмжээ.

10.4 тэрбум төгрөг (найман сая ам.доллар) – Оюу Толгой компанийн хувь эзэмшигчдээс Оюу Толгой төсөлд өдөр бүр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад зарцуулж байгаа мөнгөний хэмжээ.

15,000 – Оюу Толгой төсөл дээр ажиллаж байгаа 10 мянга гаруй монгол хүн бүхий Оюу Толгой төслийн ажиллагсдын тоо.

3,000 – 2013 онд Оюу Толгой уурхай ашиглалтад ороход тус уурхайд шууд байдлаар ажиллах монголчуудын тоо.

55 – Олон улсын валютын сангийн тооцоогоор Оюу Толгой төслийн хугацаанд татвар, ашигт малтмал олборлосны төлбөр, хураамж, ногдол ашиг байдлаар Оюу Толгойгоос Монгол Улсын Засгийн газарт ирэх ашгийн хувь хэмжээ.



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

САЛХИНЫ ҮНЭРЭЭС ХУВААЛЦАХУЙ

Хүн ам олноор суурьшиж, орчин үеийн байшин барилга сүндэрлэн, иргэдийн амьдрал ахуй ч харьцангүй дээшилж, унаа машин олноор сүлжилдэх нь баялаг ихтэй аймгийн хөгжлийг илэрхийлнэ.

Ш.ОЮУНДАРЬ

Говьд хэдийнэ хавар айлчилсан мэт дулаахан, налгар өдөр болох нь ээ. Нар Дорноос өндийж, алгуур дээшлэх нь хэзээний танил дүр төрх. Баруунаа Говь гурван сайхан уул тэр л хэвээрээ сунайж, сэвэлзэх салхинаас нь хүртэл танил үнэр ханхлах шиг. Нутгаа санасан ч байж болох, ийм сайхан дүр зураг охин, хүү бид гурвыг тоссон юм.

Улаанбаатараас Өмнөговь руу өглөө эртлэн ниссэн онгоц 01.30 цагийн дараа Даланзадгадад буулаа. Хоёр жилийн дараа нутагтаа, аав дээрээ, төрсөн гэртээ ирж байгаа минь энэ л дээ. Аавыгаа их санажээ. Ирэх бүрт л аавын минь нуруу нь бөгтийн, намхан болж, бууралтсаар. Аргагүй дээ, үзсэн туулсан нь их, хэрсүү бодол нь дэндүү гэмээр гүн хүн билээ, аав минь. Биднийг уулзаад зогсох тэрхэн зуур хамт ирсэн хүмүүс бүгд унаа тэргэндээ суугаад аймгийн төв рүү хөдөлчихөж. Бид ч бас гэрийн зүг явлаа.

Шинээр баригдсан онгоцны буудал аймгийн төвөөс долоон километрийн зайтай. Аймгийн төв хүртэл хар зам тавьж, замын хажуугаар мод тарьсан нь говийн талд содон харагдана. Аавын хэлэх нь уг модыг Хятад улсаас оруулж ирж тарьсан бөгөөд говийн уур амьсгалд зохицож сайн ургаж байгаа гэнэ.

Шинэхэн тавьсан хар зам үргэлжилсээр гэр хороололд хөтлөөд ирэв. Багадаа тоглож өссөн гудамжинд маань хар зам дурайж, айл өрхийн тоо ч нэмэгдсэн нь танигдахааргүй болжээ. Байгалийн баялаг арвин говь нутгийн минь амьдрал хөгжин цэцэглэж байгаа гэж хүмүүсийн ярих нь үнэн бололтой. Улаанбаатар хотын уул даваан дээгүүр үргэлжилсэн гэр хороололд ч ийм хар зам байхгүй шүү дээ гэж тэрхэн зуур бодогдов.

Даланзадгадад гэр хороолол нь тун цэгцтэй, хог хаягдал гудамжинд нь бараг харагдахгүй. Аймгийнхаа төвд цэцэрлэгжилт, мод ихтэй нь гаднын хүний анхаарлыг татдаг. Харин шинээр хийсэн замын дагуух гэрэлтүүлгүүд нь Улаанбаатар хотынхоос дутахааргүй өнгөлөг, чанартай юм. Уул уурхай дагаж хүн ам олноор суурьшиж, орчин үеийн байшин барилга сүндэрлэн, иргэдийн амьдрал ахуй ч харьцангүй дээшилж, унаа машин олноор сүлжилдэх нь баялаг ихтэй аймгийн хөгжлийг

илэрхийлнэ. Өмнөговь маань Монгол Улсын уул уурхайн орд газрын үүц болж дэлхийн анхааралд орчихлоо. Агаарын тээврийн төмөр хөлгүүд өдөртөө л хэд хэдэн удаа говь нутгийг зорин нисэж байна. Энэ бол хөгжлийн эхлэл.

Гэхдээ л Монгол орны хөгжил Оюутолгой, Тавантолгойн уурхайгаас ихээхэн хамааралтай талаар ам уралдуулан ярьж буй энэ үед өвөг дээдсээс үлдээсэн газрын хэвлийн баялгийг буруугаар ярьж, ашиглах вий гэсэн болгоомлол аав ээж, эмээ өвөөд маань бий. Заримдаа ч хойч үедээ үлдээх газар шороо үлдэх болов уу гэсэн бодол төрдгөө нуух юун. Яг орд илрээд буй суманд байдал тэс өөр, сэтгэл эмзэглэж, нүд халтирмаар байдаг тухай Цогтцэций сумын нэг найз маань өгүүлсэн. “Оршуулгын газруудыг ч үл тоомсорлон ухаж хөндөх хүсэлдээ хөтлөгдсөн хүмүүс их. Үнэндээ бол гаднынханд манай нутгийн хөгжил цэцэглэлт хамаагүй, хамгийн гол нь байгалийн баялгийг ухаж олборлох хүслээ биелүүлээд, гараад явбал болоо гэсэн байдлаар ханддаг” хэмээн ярьсан юм.

Том ордуудын хаялага мэдээж тухайн бүс нутагт их. Аймгийн хөгжлөөс гадна ард иргэдийн амьдрал ахуй ч ихээхэн өөрчлөгдөж буй дүр зургийг бараг айл бүрийн гаднаа сойсон бандгар жийп илтгэнэ. Гаднаас нь өнгөцхөн харвал амьдрал дээшилжээ гэж үзэх үндэстэй ч дотоод руу нь сайн өнгийвөл иргэдийн сэтгэлгээг газрын баялаг, төрийн бодлого чөдөрлөсөн мэт. Өдөрт 30 мянган төгрөгийн хөлстэй ажил хийх хүн олддоггүй гэнэ. Энэ бол бэлэнчлэх сэтгэлгээг бий болгосон сэтгэлгээний ядуурал биш гэж үү.

Нөгөө талаар баялаг балаг тарихад хүргээд байгаа юм. Байгаль орчин сүйдэж, ан амьтан нутгаасаа дайжин ховордож байгаа нь хөгжил юм гэж үү. Хэдэн зуун тоннын даацтай том машинууд хар зам татуулан урд хилийг зорин нүүрс тээвэрлэх дүр зургийг хэрхэн зохицуулах вэ. Тоосны тухайд ярихын ч хэрэггүй, говийн шар шуурга хар шуурга болсныг тэнд ажилладаг дүүгээсээ сонслоо.

Үүнээс гадна уурхай болоод тухайн бүс нутагт хамгийн том асуудал нь ус. Усгүйгээр, замгүйгээр энэ орд газруудыг яаж эдийн засгийн эргэлтэд оруулах болж байна аа.

Сайныг дагаад саар зүйл байдгийн жишээ энэ. Дээр өгүүлсэн замын дагуух гэрэлтүүлгүүд нь шөнөдөө асдаггүйн зовлонг аав маань бас хэлээд амжсан. Учир нь, Даланзадгадын цахилгаан станц нь ашиглалтад орсон цагаасаа л доголдож, цахилгаан дулаан нь үргэлж тасардагтай холбоотой. Хоёроос гурав хоног, зарим үед долоо хоногоор ч харанхуй амьдрах нь энүүхэнд ажээ. Эрчим хүчгүй болохоор даланзадгадчууд ертөнцийн мэдээллээс тасарч, гар утсаа цэнэглэх боломжгүй болно. Зарим үед аавтайгаа утсаар ярьж чаддаггүйд хүрдэг нь ийм л шаалтгаантай. Уг нь дэлхийн анхаарлын төвд орсон, гадна, дотнынхон бужигнах болсон шинэ цагийн хөрөнгө хөгжил даллах аймагт өнгөрсөн зууны бүрхэг харанхуй амьдрал үргэлжилж боломгүй санагдана.

Нэн түрүүнд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор уул уурхайгаас олсон хөрөнгө мөнгөөрөө эрчим хүчний асуудлыг нь бүрэн шийдчихвэл өмнөговьчуудын амьдрал одоо байгаагаасаа ч илүү хөгжих боломжтой. Хэдийгээр аймгийн төвд дэд бүтэц хөгжиж хот доторх замыг сайжруулж байгаа ч, Улаанбаатараас Даланзадгад руу, Даланзадгадаас уурхай руу хар зам тавигдвал хотын хөгжил орон нутаг руу чиглэж хөгжилд хүрэх зам нь болох биз ээ.

Ирэх жилийн Цагаан сараар нутагтаа дахин очиход үргэлжийн доголдолтой станц нь байнгын ажиллагаатай болж, зам харгуй нь улам сайжирч, харанхуй гудамжууд нь өнгө нэмэн гэрэлтэх сайхан ирээдүй угтаасай. Говь нутгаараа бахархах, бардамнах зүйл олон байдгийн нэг нь Даланзадгадын маань хөгжил цэцэглэлт байх болно. ■



Даланзадгадын шинэ онгоцны буудал

MONGOLIAN ECONOMY

Хаврын хавсрага Улаанбаатарын гудамж талбайгаар нэг хөглөрөх хог новшийг агаарт “бүжиглүүлээд” тун төвөгтэй. Салхины шил, амны алчууртай л явахгүй бол горьгүй. Тиймээс манай сэтгүүл шинэхэн дугаартаа нийслэлчүүд бид хогтой заваан байдлаасаа ангижрах талаар нэгийг бодож, хоёрыг хийх үүднээс хогны менежментийн асуудлыг онцлон хүргэж байна.













ХОГНЫ МЕНЕЖМЕНТ

ГОЛ ХӨШҮҮРЭГ НЬ ИРГЭДИЙН ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ

Япон улс нохойн оромж шиг унхиагүй байдлаасаа 10 хүрэхгүй жилийн дотор салж, нүд гялбам цэвэрхэн хот болсон нууц нь юу байсан талаар Киношита Сатошигаас сонирхохоо мартсангүй, залуучууд. “Нууц гээд байх зүйл байхгүй дээ. Бидэнд хогноосоо салахад хамгийн ихээр нөлөөлсөн зүйл бол иргэдийн өөрсдийн ухамсар, сэтгэхүй” гэсэн юм.

Б.УУГАНБАЯР

Навтгар шигүү байшингуудын буланд гялгар уут, чихрийн цаас, жимс, ногооны хальс хөглөрнө. Хог новш ихтэй нарийнхан гудамжаар ажил төрөлдөө яаран алхах хүмүүс идэж явсан хоолны хаягдал, цаас, шил лаазаа хүссэн газраа шидэлж орхино. /Яг манай монголчууд шиг. Төв зам дээр түгжрэн зогссон олон машины нэгнийх нь жолооч дуусан тамхиныхаа хайрцгийг цонхоороо хээвнэг чулуудах нь Монголд өнөөдөр энгийн байдаг л зүйл/.

Баримтат кино цаашаа үргэлжилж байна. Зарим нь гудамжны буланд “морь харах нь” энхүүхэнд. Тэрбитгий хэл, айлууд цонхоороо ногооны хальс, ундааны шил лааз, цаас зэрэг элдэв хог хаягдлаа сав саваар нь цацах нь манай монголчуудаас ч илүү хэнэггүй, заваан санагдана. Гудамж, талбай нь тэр аяараа хавтгайрсан хогийн цэг гэлтэй. Ялаа батгана бөөгнөрөн шавж арзганан нисэлдэнэ. Гудамжаар хөл гишгэх зайгүй шахам хөлхөх олон огтхон ч тоосон шинжгүй, зарим нь тэрхүү ялаа батгана дунд гадаа зоог барьж, баясана. Энэ бол 1960 оны Япон улсын дүр төрх.

“Зориг” сангийн Байгаль орчны манлайлал хөтөлбөрийн залуучууд ЖАЙКА олон улсын байгууллагын ажилтан, байгаль орчны боловсролын мэргэжилтэн Киношита Сатошитай уулзаж, хогны менежментийн сэдвээр ярилцсан юм. Энэ үеэр дээрх дотор эвгүйрэм баримтат киног бидэнд




1960-1970 оны Япон улсын төрх

сонирхуулан зүүлсэн. Одоогийн гял цал Их наран улс хогондоо дарагдаж, өт шавьжинд идэгдэж, иргэд нь амьсгалын замын, гэдэсний халдварт өвчин тусч байсан гашуун түүхийг тус баримтат киноноос хараагүй бол би л лав хэзээ ч итгэхгүй байсан байж магад.

Бохир хот

Баримтат киног үзэж буй залуучууд одоогийн манай Монголын гэр хорооллын, зах, худалдааны төв, цайны газар, гудамж талбайн заваан балиар төрх яг мөн байна хэмээн уулга алдан ярьцгааж байв. Тэгвэл Япон улс гахайн оромж шиг унхиагүй энэ байдлаасаа 10 хүрэхгүй жилийн дотор салж, нүд гялбам цэвэрхэн хот болсон нууц нь юу байсан талаар Киношита Сатошигаас сонирхохоо мартсангүй, залуучууд. “Нууц гээд байх зүйл байхгүй дээ. Бидэнд хогноосоо салахад хамгийн ихээр нөлөөлсөн зүйл бол иргэдийн өөрсдийн ухамсар, сэтгэхүй. Гол ▸▸



нь иргэд бидний хаясан хог эргээд эрүүл мэнд, амь насанд хохирол учруулж байсан нь гашуун туршлага болж өгсөн. Дээрээс нь манай Япон жижигхэн газар нутагтай учир хог их хаях л юм бол амьдрах газар багасч байна гэдгийг хүн бүхэн ойлгодог байсанд оршино" гэв.

Улаанбаатар хот хэрхэн хогноосоо ангижирч болох талаар асуухад тэрбээр "Танайх манай гашуун туршлагыг давтахгүй байхын тулд иргэн, олон нийт хогоо зөв хаях, хоггүй байхын ач холбогдлыг ойлгож, бие биедээ шаардлага тавин, ухуулах хэрэгтэй. Нөгөө талаас төр, засаг ч үүнд хөрөнгө мөнгө зарцуулж, анхаарлаа хандуулах нь хамгийн зөв гарц" гэсэн юм.

Нийслэл хотын маань хог шороо гаднын битгий хэл, монголчууд бид өөрсдөө ч ой гутмаар заваан байгааг хэн хүнгүй мэдэж л байгаа. Япон мэргэжилтэн одоогоос 50 гаруй жилийн өмнөх өөрийн улсын байдалтай манайхыг адилтгаж буй нь зүгээр ч нэг тохиолдол биш, өнөөдөр манайх ийм байдалтай байгаа шүү гэсэн сэрэмжлэлийг бид авч байна гэдгийг Байгаль орчны манлайлал хөтөлбөрийн оролцогч Ч.Нямсүрэн онцлон хэллээ.

Гарц

Тэгвэл бид хамтдаа юу хийж чадах вэ гэсэн асуултыг эрлээ. Үүнд хамгийн түрүүнд иргэдийн өөрсдийнх нь ухамсар, сэтгэхүйг өөрчилж, хоггүй болъё гэсэн чин хүсэл эрмэлзлэлтэй байх нь чухал гэдэгт уулзалтад оролцогчид санал нэгдсэн юм. Хотын удирдлагуудын хувьд нийслэлийн бохир заваан байдалтай эвлэрээд, зүгээр хараад суугаагүй.

Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас иргэд, аж ахуйн нэгжийн хог хаях хэв маягийг сайжруулах, анхан шатанд нь ангилуулж сургах төслийг 2009 оноос зарим дүүрэгт хэрэгжүүлж эхэлсэн нь үр дүнгээ өгч байгаа таатай мэдээ бий. Төсөл хэрэгжиж буй Хан-Уул дүүргийн хоёрдугаар хорооны хэсгийн ахлагч Ц. Эрдэнэцэцэгээс төслийн үр өгөөж хэр байгааг лавлахад "Өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас манай байшин хорооллуудад төсөл хэрэгжсэнээр иргэд хогоо анхан шатанд ангилж, хогны машиндаа цагтаа өгөх хэв маягт суралцсан. Үүний үр дүнд хиймлээр бий болсон хоёр хогийн цэг арилж, эвгүй үнэр, ялаа шумуул ч багасч буйд иргэд таатай байгаа" гэв.

Гэвч төслийн хугацаа дуусангуут эргээд хогоо ил задгай хаяад эхэлдэг байдал ч ажиглагдаж буйг Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Хог хаягдал, орчны бохирдол харицсан мэргэжилтэн С.Аригуун хэлсэн. Энэ нь манайханд хогноос болж би болоод миний үр хүүхэд өвдөж, өвчилж байна.

Тиймээс хоггүй болоход миний оролцоо хэрэгтэй гэсэн сэтгэхүй суух болоогүйг харуулж буй юм. Нөгөө талаар иргэд өөрсдөө л хогноос салах арга сэтгэхүйд суралцаж, санаачилга гаргахгүй бол хэчнээн төсөл хэрэгжүүлээд нэмэргүй нь харагдаж байна. Япон улсын жишээнээс харахад хоггүй цэвэрхэн хот болох хамгийн чухал хөшүүрэг бол иргэдийн хүсэл зориг, хувийн соёл, хогоо зөв хаях ухамсар гэдгийг тод харуулсан.

Хүсэл байвал хүч гарна

Иргэд, аж ахуйн нэгж өөрсдөө хогоо ангилан ялгаж хаях, аль болох хэрэглээгээ багасгах, ил задгай хог хаяхгүй болчихвол хогноос салах боломж бий аж. Япон хүүхдүүдэд бага ангиас нь хогоо ангилж хаях, орчин тойрноо цэвэрхэн байлгах чиглэлээр хичээл ордог байна. Манайд ч гэсэн хүүхдүүдэд багаас нь хогоо зөв боловсон хаядаг хүмүүжил олгодог болмоор байна. Түүнчлэн хамгийн чухал нь хот, дүүргийн зүгээс өрхүүддээ хогоо ангилан хаяхын ач холбогдлыг сурталчлан таниулж, гэр бүлийн хүмүүжлээр дамжуулж хүүхдүүдэд нь багаас нь ойлгуулдаг гэдгийг ЖАЙКА-гийн мэргэжилтэн Киношита онцолсон.

Дээр нь Японы томоохон хотуудад дахин боловсруулах үйлдвэрүүд байдаг нь хогны гарцыг багасгах хамгийн чухал хүчин зүйл аж. Энэ нь хогийг холивол хог, ялгавал баялаг гэдгийн жишээг тус улс харуулж байна. Тэгвэл манай нийслэлээс гарч буй хогны 60 орчим хувийг дахин боловсруулах боломжтой ч одоогоор огт боловсруулалт хийдэггүй. Дөнгөж 3-5 хувийг нь л хоёрдогч түүхий эд болгон экспортолж байгаа аж.

Харин хог боловсруулахтай холбоотой чихэнд чимэгтэй мэдээ дуулгахад БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар анхны боловсруулах үйлдвэр баригдаж буй. RPF /хаягдал цаас, хуванцарыг боловсруулах/ түлшний үйлдвэрийг ирэх сараас ашиглалтад оруулахаар зэхэж буй. Тус үйлдвэр нь Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт байрлах бөгөөд өдөрт 10-20 тонн хог хаягдлыг хүлээн авч, хоногт 1.6 тонн, сард 50 тонн орчим хаягдал цаас, хуванцрыг боловсруулж хатуу түлш үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Уг түлшийг тогтмол үйл ажиллагаа явуулдаг цахилгаан станцууд ашиглах юм байна. Тус үйлдвэр байгуулагдсанаар хотын гудамжаар эсвэл хогын цэгүүдэд хөглөрөн,

хийсч байдаг гялгар уут, хуванцар, цаас багасгаж орчны эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх юм.

Мөн хог хаягдлын хэмжээг багасгахад үр дүнгээ өгөх нэг зүйл нь Эко татварын тухай хууль гэгдийг БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн С.Мөнхбат онцолсон. Энэ нь импортоор оруулж ирж буй бараа, бүтээгдэхүүнээс тодорхой хэмжээгээр хог гарч буй учир эко татварыг бараанд шингээж өгөх аж. Үүнтэй холбоотой хуулийг ирэх намар гэхэд амжуулж УИХ-д өргөн барихаар төлөвлөж байгаа юм байна.

Өнөөдрөөс эхлээд иргэддээ хоггүй хот, хоггүй хороо, хоггүй айл болохыг уриалж яагаад болохгүй гэж. Тэгвэл үүндээ хүрэхийн тулд иргэн бүр дараах гурван зүйлийг хийж чадна. Нэгдүгээрт, Reduce буюу гаргах хогны хэмжээг багасгах, хоёрдугаарт, Reuse буюу ашиглах боломжтой эд зүйлсийг дахин ашиглаж сурах, гуравдугаарт, Recycle буюу хог хаягдлыг дахин боловсруулахыг гэр ахуйн, үйлдвэрийн аль аль шатандаа бий болгох чухал юм.

Жишээлбэл, та гэрийн нөхцөлд хогоо хаяхдаа ашиглах боломжтой бусад хэмээн хоёр ангилж, савлан хогны машинд цагтаа өгч байхаас л эхлэх аж. Мөн аль болох эко буюу даавуун эсвэл цаасан уут тор хэрэглэж занших хэрэгтэй байна. Ялангуяа дэлгүүр их хэсдэг эзэгтэй нар энэ хэвшилд манлайлан оролцох нь зүйн хэрэг. Дээр нь гадуур явахдаа аль болох идэж, уух зүйлийг хэрэглэхгүй байж хэвших, хүүхдүүддээ багаас нь хогоо ангилж ялгаж, зөв хаяж сурах дадлыг суулгаж, гэр бүлийн хүмүүжил олгох нь иргэн таны цэвэр цэмцгэр ирээдүйнхээ төлөө оруулж буй их хөрөнгө оруулалт юм.

Хог хөрсөнд задарч шингэх хугацаа



Эх сурвалж: Австралийн Куинслэнд мужийн Хог замбараагүй хаяхаас сэргийлэх холбоо

СУРВАЛЖЛАГА

ХҮНД АЖЛЫН ХЯМД ХӨЛС

Хүнд даацын “камаз” маркын машин дохиогоо хангинуулж, гэр хорооллын нарийн зам дээр түгжрэл үүсгэн уухилна. Хар өглөөгүүр хаа нэгтэйгээс сархад олоод хүртчихсэн нэгэн эр улаан зам даар унаад өгч. Том машины чанга дохиог ч мэдэх сөхөө алга.



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

Э.ЗОРИГТ

Хавар гэдэг ааш муутай хачин улирал. Саяхан л нар гарч, хаа нэгтээ болжмор жиргэж байсансан. Харин одоо салхи исгэрч, тэнгэр харанхуйлах аж. /2012 оны дөрөвдүгээр сарын 11-ны лхагва гариг, өглөөний 07:30 цаг/

Салхи гэр хорооллын хог, тоос, үнсийг хийсгэнэ. Нүүрээ алчуураар битүүлж, гартаа хар дэвтэр барьсан бүсгүй айлуудын хашааны хаалгыг балбаж “Хогоо гаргаарай” хэмээн хоолой мэдэн хашгирах ажээ. Зарим хашааны цаанаас “За” гэх дуун хадаж байхад заримаас нь нохой хуцахаас өөр чимээ алга. Чингэлтэй дүүргийн XII дугаар хорооны 16 дугаар хэсгийн ахлагч Ц.Нямсүрэн хогны машин ирэх сургаар хэсгийнхээ айлуудад урьдчилан мэдэгдэж байгаа нь энэ. Хэсгийн ахлагч бүсгүй өөрийн хариуцаж авсан хэсгийн 300 гаруй өрхийн хаалгыг хар өглөөнөөс хойш балбаж хоолойгоо сөөтөл орилсоор. Нямсүрэн “Миний хашгирах дуунаар Хайлаастын зарим иргэн уул давуулж, хогоо манай энд орхичихдог сурагтай” гэв. Тэрбээр 09:30 цагт хогны машин ирэхээс өмнө

бүх айлаараа явах хэрэгтэй хэмээн яаран одлоо.

Хог ачих “урлаг”

Хүнд даацын “камаз” маркын машин дохиогоо хангинуулж, гэр хорооллын нарийн зам дээр түгжрэл үүсгэн уухилна. Хар өглөөгүүр хаа нэгтэйгээс сархад олоод хүртчихсэн нэгэн эр улаан зам даар унаад өгч. Том машины чанга дохиог ч мэдэх сөхөө алга. /Өглөөний 09:45 цаг/

Хогны машины ачаан дээр хоёр залуухан эр зогсох бөгөөд ажлын муу хувцас өмсөж, саравчтай малгай духдуулж, амны хаалт зүүжээ. Тэднийг иргэн Б, иргэн О гэдэг. Залуусыг нэрний эхний үсгээр ийнхүү нэрлэсэн нь учиртай. Хог ачигч нар ихэвчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр ажилладаг учраас хамаагүй яриа өгөх, өөр бусад хүмүүстэй харьцах хориотой байдаг ажээ. Тиймээс тэд нэрээ нууцлахыг хүссэн юм.

Үнс, шорооноос авахуулаад юу л байна бүгдийг мань хоёр машин дээр ачина. Гэхдээ хог ачихад басхүү урлаг хэрэгтэй аж. Иргэн Б “Хог ачихад учир бий. Хамгийн түрүүнд иргэдийн ангилж ялгалгүй холиод хаячихсан хогийг бид хоёр ялгана. Айлуудын хаясан хогийг харж байхад үнс, ногооны хогноос бусад нь бараг л дахин ашиглагдаж болмоор юмс байдаг. Адаглаад хөнгөн цагаан, архи пивоны шил, ундааны лааз гээд л. Бид нэг удаагийн ачилтаар ялгасан хогоо тушаагаад өдрийнхөө хоолны мөнгийг олчихдог л юм” гэв. Тэдний хог ачсан хөлсийг жингээр нь бодож олгодог учраас аль болох их хог ачихыг хүсдэг аж.

Шинэ ачигч нар ихэвчлэн нэг ачилтаар дунджаар зургаа орчим тонн хог ачиж чаддаг байна. Харин мань хоёр жил хэртэй ажилласан болохоор 8-9 тонн хүртэл хог ачдаг гэж сайрхав. Иргэн Б “Хогийг сайн ачихын тулд дээр хэлсэнчлэн ангилаад дараа нь хамгийн зөөлөн хогийг доод хэсэгт асгаж, түүнийгээ дээрээс нь гишгэж сайтар дагтиршуулсны дараа арай хатууг нь дээр дээрээс нь асгадаг. Үүний дараа завсар зайгаар нь үнс шороо гээд нарийн ширхэгтэй хогийг чигжиж өгснөөр их хог ачих боломж бүрдэнэ. Тэгээд хамгийн сүүлд шуудайтай хогоо нийт ачаагаа хашсан байдалтай тавьж өгөх хэрэгтэй” гэв. Харин иргэн О “Хог ачих нэг талаар хэцүү. Өвлийн цагт гар хөл хөлдөөчих гээд. Түүнчлэн халуун үнс ачиж болохгүй гал гарах аюултай учраас хөртөл нь хүлээх хэрэг гарна. Зуны цагт нь үнс, тоос багасаад 7.5 тонн хог ачих нормоо биелүүлэх гэж нусаа хацартаа наасан хэрэг болно” хэмээн ярилаа. Тэднээс хэдэн төгрөгийн цалин авдгийг нь тодруулахад “Болохгүй” гээд халгаасангүй. Хог ачихад юу хамгийн хэцүү вэ гэхэд мөрөө хавчаад өнгөрлөө.

Хогчин авгай

Айлуудын хашааныхаа үүдэнд гаргасан хогны ихэнх нь 200-гийн хүнд төмөр савтай байх агаад зарим нь ямар ч савгүй их хог овоолсон харагдана. Хаврын салхи хог ачигчдын ундууцлыг бишгүй хүргэх аж. Ам хамар руу нь үнс тоос орохоос аваад, ачих гэж байсан хогийг нь хийсгэчих жишээтэй. /Өглөөний 10:20 цаг/

Чингэлтэй дүүргийн XII дугаар хорооны хогны байцаагч Б.Цэндээ бүсгүй ажлаа хийж явна. Тэрбээр долоо хоногийн гурав дахь өдөр л амрах боломжтой аж. Гэхдээ өнөөдөр лхагва гариг. Гэсэн ч тэр ажиллахаар ирсэн нь энэ. Учир нь, хог ачих машин хүрэлцээгүй байсан учраас машин олдсон дээр нь гээд өнөөдөр ажиллаж байгаа аж. 15 гаруй жил хогны байцаагчаар ажилласан тэрбээр өдгөө “Хогчин авгай” гэх хочтой болжээ. Зарим нэг оршин суугчид Цэндмаагийн нэрийг үл мэдэх бөгөөд “Хогчин авгай” гэдгээр нь илүүтэй таних аж. Сардаа 250 мянган төгрөгийн цалинтай түүний ажил хүнд. Айлуудын хашааны хаалгыг балбахаас эхлээд хийссэн хогны араас гүйх, ачигч нарынхаа хүч хүрэхгүй зарим хогийг хамт өргөлцөх, өсгийгөө “эргэтэл” алхах, хогоо ачуулсан эс ачуулсан талаар маргалдах гээд л. Харин Цэндээ “Миний ажил харьцангуй хөнгөрчихөөд









ФОТОГ Э.ЗОРИГТ

байна. Өмнө нь би хар өглөөгүүр л хогоо гаргаарай гэж орилдог, хогны мөнгийг нь хураах гэж хүн амьтантай муудалцах асуудал мундахгүй гардаг байсан. Харин одоо хогны мөнгийг гэрлийн хураамжтай цугт нь авчихдаг, хэсгийн ахлагч нар нь миний өмнөөс “Хогоо гарга” гээд гүйчихдэг болсон. Тэгэхээр миний ажил нугар ч л байна” хэмээв.

Харин түүнд нэг ажил шинээр нэмэгджээ. Тэр нь хогоо гаргаагүй айл бүрийн хаалга дээр мэдэгдэх хуудас наах. Учир нь, иргэд гэртээ байхгүй өдрүүдэд хог ачаад явахаар мэдээгүй зарим нь гомдоллох нь их байдаг аж. Хогны мөнгийг цахилгааны төлбөртэй хамтатгаж авдаг болсноос хойш иргэд хогоо ачихад тусалдаг байсан бол одоо ихэнх нь тоохоо байжээ. Энэ талаар хогны байцаагч “Иргэд хогоо ачихад туслах битгий хэл зарим нь хогоо хашааныхаа үүдэнд гаргахаас залхуурдаг болсон. Хогоо ялгадаг байсан айлууд нь үүдэндээ овоолчихдог болж. Өмнө нь оршин суугчид хогны мөнгөн дээрээ луу унжиж, эсвэл хоёр гурван сарын мөнгөө цуглуулж өгдөг байсан болохоор байцаагчийн хэлснийг дагадаг байсан юм шиг байна. Харин одоо миний үгийг нохой хуцахын чинээ тоохоо болчихсон” гэв.

Хогны машин тоос манарган уухилсаар, хоёр ачигч залуу “нэг хоёрын гурваа” хэмээн өөрсөддөө хүч нэмэн хогоо ачсаар.

Мэргэшсэн мэргэжил

Чингэлтэй дүүргийн XII дугаар хороо хогноосоо салахын тулд эко эргүүл гэх ажлын байр шинээр бий болгожээ. Одоогоор уг ажлыг 10 гаруй иргэн хийж байгаа аж. Түүний нэг нь Д.Тайван 40 гаруй насны эр юм. Тэрбээр “Ах нь өмнө нь хувиараа хог түүж хэдэн төгрөг олдог байлаа. Харин одоо хувьсгалын хогийг түүж цалинтай, ажлын байртай болсон. Одоо ч бараг хог түүх ахынх нь ганц мэргэшсэн ажил болсон байх. Нөгөө насаараа л багш хийлээ гэдэг шиг насаараа хог түүлээ гэхэд хилсдэхгүй” хэмээн инээв.

Эко эргүүлүүд жалга дов, гудамжны хогийг цэвэрлэдэг аж. Тэд өдрийн 9000 төгрөгөөр цалинждаг бөгөөд сарын 10 хоног ажиллах даалгавартай. Гэхдээ үлдсэн өдрүүдэд нь зүгээр суудаггүй. Эко эргүүлийн дарга С.Даваасүрэн бүсгүй “Манайхан хогоо гэрээсээ л гаргаж байвал барав гээд хаа сайгүй хаях юм. Тэр дундаа манай хэсгийн 751, 752 дугаар хашааныхан хэлээд үг авахгүй. Үерийн далан руу хог битгий хая. Энэ чинь хогны далан биш гэхээр чихгүй толгойлоод асгасаар л байна. Дээрээс нь угаадсаа асгаад үнэр танар гэж авах юмгүй. Ийм орчныг бид сарын 10-хан хоног ажиллаад хогноос нь салгаж чадахгүй байна. Хэсгийн ахлагч нар хогоо сайн түүсэнгүй гээд мань мэтийг л загнадаг. Гэхдээ бид түүгээд л эргээд харахад оршин суугчдын нэг нь угаадсаа асгаж, хогоо шидэж харагддаг” гэлээ.

Санал гомдол

Чингэлтэй дүүргийн зарим иргэн хогны машин цагтаа ирж хогоо ачдаггүй талаар гомдоллож байсан. Тухайлбал, 16 дугаар хэсгийн 750 тоотод оршин суудаг Л.Оюун “Хогны мөнгийг байцаагч нь хураадаг байхдаа сар сардаа ачдаг байсан чинь одоо нэг л сайн ачихгүй байна. Цагаан сараар гэхэд бараг битүүний урд өдөр ачсан. Тэрнээс хойш нэгээс хоёр л ачсан байх. Өөрсдөө хогоо цаг тухайд нь ачихгүй байж биднийг хог ил асгалаа гээд загнах юм. Сардаа ганц удаа ирэхдээ цаг тухайд нь ирээд л байвал асуудалгүй ш дээ” гэв.

Өглөө 10:20 цагаас хог ачиж эхэлсэн байцаагч, ачигч, жолооч дөрөв нэг мэдэх нь ээ өдрийн 13:05 цаг хүртэл ажиллачихаж. Өмссөн зүүснээс аваад хамрын самсаа, хөмсөг нүдгүй үнс, тоосонд даруулсан тэд машинаа дүүргээд Чулуутын хогийн цэгийг зорилоо. Тус хог ачсан хэсгээс Чулуутын хогийн цэг хүртэл дунджаар гурван цаг явдаг аж. Тэнд очоод хогоо жигнүүлж, холбогдох баримтыг бөглөсний дараа хогоо асгана. Тэдний ачсан хог 9.4 тонн болжээ.

Энд тэндгүй хог. Золбин ноход, муу хувцастай хар шуудай үүрсэн хүмүүс хогон далайд олз хайн тэмтчинэ. / Өдрийн 17:37 цаг/ ■



ФОТОГ Э.ЗОРИГТ

ТЕХНОЛОГИ

ТОЛГОЙГОО АЖИЛЛУУЛЖ, МӨНГӨ ОЛДОГ ШИНЭ БИЗНЕСИЙГ БИЙ БОЛГОЛОО

Хамгийн сүүлийн үеийн мэдээлэл технологийг бусдаас түрүүлж хэрэглэх, мөн нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилготой Харилцаа холбооны зохицуулах газрын дарга Б.Болдбаатартай ярилцлаа. Түүний өмнө IPAD, хоёр гар утас нь байна. Тэрбээр дөрвөн үүрэн телефоныхоо хэрэглэгч нь. Монголын өргөн уудам газар нутгийг хэрсэн шилэн кабелийн сүлжээг байгуулах, энэ олон интернэт, телевиз, радио, үүрэн телефоны компаниудын үйл ажиллагаанд зохицуулалт хийх гэх мэт ажил ихтэй тус байгууллагын удирдлага сайнаар дуудуулж, сарааар ч хэлүүлэх үе бишгүй тохиолдоно. Зургаан жилийн өмнө 10 тэрбум төгрөг улсад төлдөг байсан салбар өнгөрсөн онд 100 тэрбум төгрөг тушаажээ. Энэ бол зохицуулах газрын ажил хэр явааг дүгнэх нэг том үзүүлэлт. Тус салбарынхан өөрсдийгөө уул уурхайгаас хол, байгальд ээлтэй бизнес эрхэлдэг хүмүүс гэцгээдэг. Бидний ярилцлага энэ сэдвээс эхэлсэн юм.

Д.БЭХЭЭ

-Харилцаа холбооны салбарыг байгальд ээлтэй бизнес гэдэг. Тэгвэл Та үүнийг ямар жишээгээр батлах вэ?

-Харилцаа холбооны салбарын гол тулгуур нь хүний хэл, яриа юм. Хүний яриаг дамжуулахын тулд бид утастай, утасгүй холбоог ашиглаж байна. Хуучин бол суурин утсаар дамждаг байсан. Харин өнөөдөр утасгүй холбоогоор өөр хоорондоо харьцаж байна. Ингэхдээ бид агаарын долгион гэх байгальд ээлтэй технологийг ашигладаг. Бидний эргэн тойронд байгаа байгалийн бас нэгэн баялаг болсон агаар, хоосон зайг ашиглаж бизнес явуулж байна. Энэ агуулгаараа байгальд үнэхээрийн ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болно.

Дэлхийн хамгийн анхны харилцаа холбооны байгууллага 1865 онд байгуулагдсан. Байгуулагдсан шалтгаан нь хэдийгээр улс, үндэстэн бүр өөр өөрийн гэсэн хил хязгаартай ч өөр хоорондоо харилцах хэрэгтэй. Харилцахын тулд агаарын долгионы нэг давтамжийг ашиглаж болох юм гэдгийг нээсэн. Тэр өдрөөс хойш харилцаа холбооны салбар даяаршлын суурь нөхцөлийг

бүрдүүлж буй том хүчин зүйл болсон. Мөн жирийн иргэн, хэрэглэгчдэд ч орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан асар том боломжийг бүрдүүлж өгч байна.

-Харилцаа холбооны салбар маань харьцангуй өндөр технологийн хөгжилд суурилсан салбар. Дэлхийн хөгжлийн хаахна явна вэ, манайх?

-Дэлхий нийтэд ер нь харилцаа холбооны салбар өндөр хөгжиж байна. Энэ талын хөгжлийг юугаар хэмждэг гэхээр онгоцоор нисэж байгаа, эрчим хүч, машин, гар утас хэрэглэдэг хүний тоо гэсэн олон хүчин зүйлийг харьцуулж гаргаж ирдэг. Өнөөдөр дэлхий дээрх долоон тэрбум хүн амын зургаа нь технологийн дэвшлийг хүртэж байна. Тухайбал, хүний өдөр тутмын амьдралд харилцаа холбооны техник, технологи идэх хоол, уух цай шиг нь байнгын хэрэглээ болсон гэдгээс харж болно. Энэ бол гайхамшиг. Мөн дэлхийн аль ч өнцөгт байсан өөр хоорондоо харьцах боломжийг энэ салбар л бий болгож чадсан. Тэр ч бүү хэл өдөр шөнийн заагүй ажилладаг ховорхон салбар бол харилцаа холбоо юм.

Саяхан манай харилцаа холбооны зохицуулах салбар Азийн зохицуулагчдын хурал зөвлөлгөөнд оролцоод ирлээ. Эндээс харахад манай орны харилцаа холбооны салбар нэлээд өндөр түвшинд хүрсэн нь харагдаж байсан. Тухайлбал, 2011 оны эцсээр гаргасан дүнгээр хоёр сая 950 орчим гар утас хэрэглэгчидтэй болсон байна. Энэ нь нийт хүн амын 104 хувийг эзэлж байгаа юм. Буурай хөгжилтэй орондийм үзүүлэлт байхгүй. Дээрээс нь интернэт хэрэглэгчдийн тоо нэг сая гарчихлаа. Бидний энэ түвшинд хүрч чадсаны гол учир нь иргэдийн амьжиргаанд тохирсон үнэ тариф тогтоож чадсантай холбоотой.

-Харилцаа холбооны салбарт үнийн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадсан гэсэн үг үү?

-Үнэ тарифын асуудлаа зөв зохицуулж чадсан оронд энэ салбарын технологи илүү хүртээмжтэй байдаг. Бид 2010 оноос үнийн хүндрэлтэй асуудлуудыг шийдэж чадсан. Тухайлбал, Монгол Улсын хамгийн алслагдмал цэгээс Улаанбаатар хот руу ярихад нэг л үнээр ярих боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр салбарын хамрах хүрээ тэлж, хүн бүрт хүрч үйлчлэх боломжийг бүрдүүлж байгаа юм. За тэгээд хотын иргэдийн хувьд хөдөлгөөнт болон суурин интернэт, төрөл бүрийн гар утасны үйлчилгээ гээд технологийн дэвшлийг сайн хүртэж байна. Энэ бүгдээс аваад үзэхэд манайх хэрэглэгчдийн тал дээр салбартаа тэргүүлэгч орнуудын ар шил дээр яваа. Гэхдээ дан ганц хэрэглээд л яваад байвал тэр хөгжил биш. Тиймээс бид өнөөдөр тэр өндөр технологийг бүтээдэг болмоор байна.

-Тэрхүү өндөр технологийг монголчууд хэрхэн бүтээх вэ?

-Саяхан олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2015 он гэхэд дэлхийн хүн амын 40 гаруй хувь нь өндөр хурдны интернэттэй холбогдсон байх ёстой. 50 гаруй хувь нь өндөр хурдны биш юмаа гэхэд ямар ч байсан интернэтэд холбогдсон байх ёстой зэрэг шаардлага тавьсан. Бидний хувьд ч мөн ялгаагүй 2015 он хүртэлх төлөвлөгөөгөө гаргаад явж байгаа. Хэрвээ ажил төлөвлөсний дагуу явбал Монгол Улсын нийт хүн амын 90-иэс дээш хувь нь өндөр хурдны интернэттэй холбогдох юм. Ингэж чадвал өнөөдөр технологийн салбартаа тэргүүлэгч Япон, Америк, Солонгос, Канад зэрэг орнын хэрэглэгчдийн хэрэглэдэг тэр бүх үйлчилгээг орон нутгийн ямар ч иргэн хүртэх боломжоор хангагдах юм. Энэ бүхэн бол үйлчилгээний тухайд юм.

Харин толгойгоо ажиллуулж мөнгө олдог шинэ бизнес буюу “Контент”-ийн бизнес манай салбарт шинээр бий болж байна. Энэ салбараа дэмжиж чадвал бид зөвхөн өөрийн орны бус олон улсын зах зээл дээр гарч өрсөлдөх боломжоо нэмэгдүүлэх юм. Энэ боломж бүрдээд, бид хөгжүүлж чадвал гаднын орнуудтай эн зэрэгцэх боломжтой.

Хэрэглэгчдийн тухайд 2006 оноос нэлээд зоримог, шийдэмгий ажилласны дүнд манай оронд бүх төрлийн өндөр технологид богино хугацаанд нэвтэрч орж ирж чаддаг болсон. Өнөөдөр гаднын буурай хөгжилтэй орнуудад тоон телевиз, 4G гэдэг ч юм уу өндөр технологиудыг хэрэглэх нь битгий хэл, сонсоо ч үгүй яваа хүн олон бий шүү дээ.

-Өнөөдрийн байдлаар шилэн кабельд холбогдоогүй хэчнээн сум байгаа вэ?

-Бид өнгөрсөн жилээс эхлээд БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр шилэн кабелийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулж байна. Өнгөрсөн жилийн хөрөнгө оруулалтаар нийт сүлжээний уртыг хоёр дахин өсгөжээ. Өмнө нь 10 мянга орчим урт сүлжээтэй байсан бол одоо 20 мянга орчим болсон. Өнөөдөр 50 орчим сум интернэтэд холбогдож чадаагүй байна. Тиймээс шилэн кабелийн сүлжээг цаашид нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа. Гэхдээ энэ ажлыг явуулахад газар зүйн хувьд хүндрэлтэй аймгууд бий. Тухайлбал, Алтай нурууны аймгууд. Газар зүйн байрлал болохгүй гээд гараа хумихаад сууж таарахгүй. Өөр ямар гарц байгааг хайж, өндөр хурдны интернэтэд холбоно. Энэ зорилгын хүрээнд 2016 он гэхэд бүх аймаг өндөр хурдны интернэт суурилуулах зорилгыг өмнөө тавьсан.

-Харилцаа холбооны технологийн хөгжил хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнээс хамаарааД шинэ зохицуулалт шаардах нь мэдээж. Тэгвэл танай газраас зохицуулалтын ямар ажил хийж байна вэ?

-Харилцаа холбооны салбар хурдтай хөгжиж байна. Өмнө нь тухайн салбарт зөвхөн утсаар ярих л хамаардаг байсан бол одоо интернэт, зурагт, радио, цахим ертөнцийн аюулгүй байдал зэрэг олон асуудал хамаардаг болчихож. Интернэтийг ашигласан бусад салбарын үйлчилгээ ч зохицуулалт шаардаж байна. Энэ утгаараа Зохицуулах газар байх нь зайлшгүй. НҮБ-д нэгдсэн 200 гаруй орноос 160 орчим нь харилцаа холбооны салбараа зохицуулах газартай байдаг. Уг зохицуулах газар нь юу хийх вэ гэхээр дээрх бүх үйл ажиллагааг нэгтгэсэн, бизнест хэрхэн ээлтэй зохицуулалт хийх талд толгойгоо ажиллуулдаг. Бизнест ээлтэй зохицуулалт хийснээр бизнесийн салбарын үр ашиг нэмэгдэж, тэр хэмжээгээр төрд төлөх татварын хэмжээ нэмэгдэнэ.

2006 онд манай салбар 10 орчим



тэрбум төгрөгийн татвар төлдөг байсан бол 2011 оны байдлаар 100 орчим тэрбумын татварыг улсад төлж байна. Энэ нь зохицуулалт зөв явж байгаагийн илрэл юм. Зөв зохицуулалт хийх хэд хэдэн шаардлага байдаг. Тухайлбал, миний дээр хэлсэн харилцаа холбооны салбар даяаршлын хамгийн том хөдөлгөх хүч болж буй тул Зохицуулах газар нь төрөөс хараат бус, оператор компаниуддаа эрх тэгш ханддаг байх хэрэгтэй. Манай орны хувьд эдгээр шаардлагад нийцэж ажилладаг төдийгүй төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хослуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

-Манайд дөрвөн опператор компани үйл ажиллагаа явуулж, өрсөлдөж байна. Харин цаашдаа өөр үүрэн холбооны оператор компани нэмэгдэх үү?

-Огт нэмэгдэхгүй гэж хэлж чадахгүй бас нэмэгдэнэ ч гэж хэлж болохгүй. Нэмэгдэхгүй гэвэл хэрэглэгчдийн дунд хуучинтайгаа л зууралдаад байх юм гэсэн сөрөг ойлголтыг авчирч болзошгүй. Нэмэгдэнэ гэвэл хуучин компаниудад хүлээлт бий болж, цаашлаад зах зээл үймүүлэх ч сөрөг үр дагавар гарч болно. Тиймээс судалгаа хийгээгүй байж энэ талаар хоосон ярьж болохгүй. Бидний 2010 онд хийсэн судалгаагаар манай зах зээл дээр дөрвөн компани үйл ажиллагаа явуулж болох юм гэдгийг тогтоосон. Үүндээ тулгуурлаад үнийн хувьд хоёр дахин буурах боломжийг олж харсан. Тийм учраас л өнөөдөр үүрэн холбооны дөрвөн оператор үйл ажиллагаа явуулж байна.

-Монгол Улс хиймэл дагуултай болно гэсэн сайн мэдээ сонсогдож байна. Энэ мөч хэзээ ирэх вэ?

-Хиймэл дагуулын асуудал хэцүү. Гэхдээ энэ талаар судалж үзээд хиймэл дагуултай болж болох юм гэдэг урьдчилсан дүгнэлт гаргах нь тусдаа асуудал. Одоогоор судалгааны шатандаа явна. Ер нь хиймэл дагуултай болох нь Монгол Улсын хувьд нэн шаардлагатай асуудал. Айл бүр машинтай болох зорилго өмнөө тавьдаг шиг манай улсын өмнөө тавьсан зорилгын нэг яах аргагүй хиймэл дагуул юм. Гэхдээ энэ нь тийм амар ажил биш ээ.

-Хиймэл дагуулыг ямар зорилгоор түлхүү ашиглаж болох вэ?

-Энэ нь хоёр янзын технологитой байдаг. Эхнийх нь харилцаа холбооны салбарт, нөгөөх нь цаг агаар, агаарын тандан судалгаа зэрэгт зориулагдсан байдаг. Бид энэ талаар судалж байна. Манай орны хувьд хоёуланг нь хөөргөх хөрөнгө мөнгөний бололцоо муу. Дээрээс нь зах зээл нь жижигхэн. Тиймээс аль нэгийг нь сонгож таарах байх. Бид ирэх сарын сүүлчээр энэ чиглэлийн олон улсын хурал зөвлөлгөөн зохиох төлөвлөгөөтэй байгаа. Энэ үеэр гаднын орнуудын туршлагаас судалж, өөрийн орны нөөц бололцоог тодорхойлсны үндсэн дээр нэг шийдвэрт хүрэх болов уу.

-Танай газраас хүүхдэд зориулсан цахим сайт гаргасан гэсэн. Энэ талаараа тодруулахгүй юу?

-Интернэтийг хөгжүүлэх нь бидний үүрэг. Хөгжөөд ирэхээрээ бас сөрөг үр дагавартай. Тухайлбал, нийгэмд сөрөг мэдээлэл тараах, хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх гэх мэт. Хамгийн гол нь улс орондоо зүй зохистой интернэтийг хөгжүүлэх ёстой. Тэр утгаараа хүүхдийн байгуулагуудтай хамтраад хүүхдэд зориулсан цахим сайт нээн ажиллуулаж байгаа. Үүгээрээ дамжуулаад интернэтийн аюулгүй байдлыг сайжруулахыг зорьж байна. Энэ бол дөнгөж эхлэл. Цаашдаа илүү олон ажил хийхээр төлөвлөсөн байгаа.

-Манайх олон телевиз, кабелийн сувагтай байна. Цөөхөн хүн амтай улсад ийм олон телевизийн хэрэгсэл байх шаардлагатай эсэх талаар таны бодлыг сонсоё?

-Харилцаа холбооны салбар хөгжих явцад олон сайхан боломж бий болж байна. Өөрийн хийсэн бүтээлээ гаднын үзэгч, сонсогчдод хүргэх гэдэг ч юм уу. Гэхдээ таны хэлдэг зөв. Аливаа улс энэ тал дээр зохицуулалт хийх нь зүй ёсны хэрэг. Тэр үүднээсээ ирэх сараас телевизийн шинэ суваг нээх эрхийг түр хугацаагаар хориглож байгаа. Өөрийн чинь хэлснээр хэтэрхий олон телевизийн сувгаар хэрэгтэй хэрэггүй мэдээлэл гараад байгаа юм биш байгаа гэдэг дээр ярилцаж байна. Телевиз, радиогийн нэвтрүүлэгт тавигдах шаардлагыг шинээр гаргасан. Хэдийгээр бид шинэ суваг нээх эрхийг түр хугацаагаар хааж байгаа ч учиргүй захиргаадах хэлбэрт шилжиж болохгүй.

Ер нь аливаа зүйл зах зээлийнхээ горимоор шийдэгдэх нь илүү эрүүл байдаг. Харин бид алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, гарвал засах тал дээр анхаарах хэрэгтэй. Дээрээс нь хүмүүс аливаа зүйлийг голдуу бараан талаас нь хараад байх шиг. Өнөөдөр олон суваг бий боллоо гэж байв ч тэр сувгуудаар олон сайхан нэвтрүүлэг, монгол кино гарч байна гэдгийг бодох хэрэгтэй. Дэлхий дахины мэдээ мэдээллийг бид цаг алдалгүй хэрхэн хүлээн авч байгаа билээ. Өмнө нь хөл бөмбөгийн дэлхийн аваргын тэмцээнийг олон сувгаар шууд хүлээн авч үздэг байсан бил үү. Харин өнөөдөр монголчууд олимпийн аваргын алтан медиаль авах тэр торгон агшинг шууд хүлээн авч үзэж байна. Энэ бол том хөгжил дэвшил.

-Харилцаа холбооны зохиуулах газар телевизүүдийн бодлогод нөлөөлдөг үү? Зарим телевизийн газраас ийм гомдол гардаг.

-Манайхаас тодорхой дүрэм журам гаргаж байгааг бодлогод нөлөөлж



байна гэж үздэг тал бий. Тухайлбал, нэг цаг гарч байгаа нэвтрүүлгийн нийт цагийн дөрөвний нэгээс /15 минут/ ихгүй хувьд зар сурталчилгаа явуулна гэсэн шаардлага тавьсан. Олон улсын жишиг 12 минут. Мөн нэвтрүүлгийн 50-иас дээш хувийг өөрийн оронд бүтээсэн байх ёстой. Дээрээс нь зохиогчийн эрхийг хүндэтгэх, садар самууныг сурталчлахгүй байх зэргийг манай газар тухайн телевизээс шаарддаг. Эдгээр шаардлагыг биелүүлж байгаа эсэх дээр судалгаа хийхэд зөрчил их байна. Тиймээс бид эдгээр шаардлагыг биелүүлэх талаар шаардаж байгаа нь үнэн. Телевизийн бодлогод нөлөөлж байгаа асуудал биш юм.

-Зөрчлийг арилгах талаар ямар арга хэмжээ авдаг вэ?

-Хэрвээ дээрх шаардлагыг биелүүлэхгүй бол бид тухайн телевизэд торгууль ногдуулдаг болох юм. Гэхдээ нэг шийдвэр гаргаад л маргааш нь шууд хэрэгжих ёстой гэсэн өндөр шаардлага тавихгүй. Эхлээд танайх энэ шаардлагыг биелүүлэх юм бол ийм ийм давуу талтай болно гэдэг дээр зөвлөгөө өгч эхэлж байна. Тухайлбал, 15 минут кино гаргаад 30 минут зар сурталчилгаа цацаад байвал Та нар өөрсдөө л үзэгчдээ алдах болно гэдэг ч юм уу. Харин сүүлийн үед зарим телевиз ойлгож, хүлээн авч хэрэгжүүлдэг болсон. Хэрэгжүүлж чадахгүй нэг нь яагаад гэдгээ мэдэгдэж байна. Энэ бол бас нэг алхам. Бүх телевиз удахгүй тоон системд шилжихээр энэ бүх асуудал цаанаасаа программын дагуу шийдэгддэг болно.

-Та зохицуулах газрын даргын албыг хэдэн жил хашиж байна вэ?

-Би 2006 оны нэгдүгээр сараас энэ албанд томилогдсон.

-Тус салбарыг толгойлоод зургаан жил болсон байна. Ер нь хэр хэцүү ажил вэ?

-Нэг талаараа их сайхан. Хамгийн наад зах нь технологийн дэвшилтэй түрүүлж танилцах боломжтой. Холыг ойртуулж, хоёрыг уулзуулж байна гээд дурдаад байвал сайхан зүйл олон шүү дээ манай салбар. Нөгөө талаасаа амаргүй ээ. Жижиг сажиг хэл ам, хэрүүл зарга огт тасрахгүй. Энэ утгаараа стресстэх асуудал гарна.

-Шинэ технологитой түрүүлж танилцдаг гэлээ. Та яг одоогоор ямар шинэ технологиуд хэрэглэж байна вэ?

-Өдөр тутам 3G-г ашиглаж дэлхийн аль өнцөгт юу болж байгааг цаг алдалгүй мэдэж байна. Гар утсаар ажлаа амжуулж, өөрийн хүссэн дуу, бичлэгээ татчихаж байна. Интернэтээр хүссэн цагтаа аялах боломжтой. Гэртээ “Univsion” телевизийг үзэж байна. Хөл бөмбөгийн урд шөнийн тоглолтыг ухраагаад үзчихдэг. Ийм л байх шив дээ. Ер нь бид харилцаа холбооны салбарын өндөр технологиудыг сайн мэддэг, ашигладаг байх хэрэгтэй. Зарим хүмүүс энэ салбарын үр ашгийг сайн мэдэрдэггүй юм шиг санагддаг. Хамгийн наад зах нь бид аливаа ажлыг орон зайнаас үл хамаарч, гар утсаараа хялбархан зохицуулчихдаг. Хэрвээ гар утас байхгүй байсан бол нэг хүнтэй уулзах гэж л бүтэн өдрийн талыг барна шүү дээ. Зарим хүн утасны төлбөр их гарлаа гээд бухимддаг. Гэхдээ бухимдахын оронд Та ямар их цаг зав хэмнэсэн гэдгээ бодоод үз.

-Та хэдэн гар утастай вэ?

-Хоёр гар утас барьж байна. Зургаа, долоон дугаартай. Тус бүрийг нь өөр өөр зорилгоор ашигладаг.

-Улс орны хөгжил уул уурхай дээр тулгуурлаж байна. Үүнийг Та ямар өнцгөөс харж байна вэ?

-Уул уурхай бусад салбараа дэмжиж л ажиллах хэрэгтэй. Тухайлбал, Оюутолгой компани эхлээд холбооны ажлаа ч өөрсдөө хийнэ гэж байсан. Энэ нь буруу юм. Тиймээс бид танайх манай үүрэн холбооны операторуудаас үйлчилгээ ав гэсэн шаардлага дээрээ хатуу зогссон. Яагаад гэвэл бэлэн байгаа юмыг заавал шинээр бий болгохын хэрэг юу байна вэ. Мөн бидний хийх ёстой ажлыг тэд хийгээд байвал юу болох вэ. Тэгэхээр хамтран ажиллах нь илүү зөв. Оюутолгой ч бидний энэ шаардлагыг зөвшөөрч, одоо “Мобиком”-оор үйлчлүүлж байгаа. Бид дор бүртээ аминчхан үзлээсээ татгалзах хэрэгтэй. Хөгжихгүй шүү дээ. Чаддаг хүмүүст нь чадахгүй байгаа зүйлээ даатгачих.

- Танай байгууллагын хамгийн ойрын хийх гэж буй томоохон ажил юу вэ?

-Бид телевизийн салбарыг 2014 оны долоодугаар сарын 31 гэхэд тоон технологид бүрэн шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ бол маш том ажил. ■



БОНД

ДАВАЛГААГ ДАГА

Гурав дахь бондыг “Хас” банк гаргах гэж байна. Хөрөнгө оруулагчид дахин нэг Монголын байгууллагад мөнгө зарах болов уу?

ТЕРРЭНС ЭДВАРДС /Mongolian Economy” сэтгүүлийн англи хэлний редактор/

Гаднын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын өсөлтийн их далайд шумбах боломж олдлоо. Хөгжлийн банк, Монголын уул уурхайн корпорациас эхэлсэн өрийн бичиг арилжаалах давалгааг хамгийн сүүлд “Голомт” банк дагах хүсэлтэй буйгаа дуулгаж Монголд бондын шинэ эрин эхлэв. Үүнийг сүүлийн хоёр жилд уул уурхайн эрчимтэй хөгжлөөс улбаалсан хөрөнгө оруулалтын их урсгалын дээд цэг гэж үзэж болохуйц үйл явдал юм. Хэдийгээр энэ гурван байгууллага улсынхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах сайн зүйл хийж байгаа ч өсөлт хөгжилд тэмүүлсэн Монгол Улсад дахиад хөрөнгө хэрэгтэй. Харин дээрх олон улсын зах зээл дээр амжилттай арилжсан, арилжих гэж байгаа өрийн бичгийн саналууд нь ирээдүйд хийх үйл ажиллагаанд анхан шатны мэдээллийн бааз бий болгоход чухал болохыг харуулж байгаа юм.

“Хас” банк өнгөрсөн сард Хөгжлийн банкнаас гадаадын зах зээлд борлуулахаар гаргасан үнэт цаастай ижил төрлийн 300 сая ам.долларын Euro Medium Term Note үнэт цаасыг арилжаалахаазарласанчхойшлуулаад байгаа билээ. Хөгжлийн банкныхны мэдээлж буйгаар тус банкны 580 сая ам.долларын үнэт цаасны захиалга зарласан үнээсээ даруй 13 дахин их байсан төдийгүй нийт 6.6 тэрбум ам.долларын ашиг хүртсэн аж. Мөн Монголын уул уурхайн корпорацийн 600 сая ам.долларын өрийн бичгийн борлуулалт 5.5 тэрбум ам.долларын ашигтай байжээ.

Цоо шинэ

Монгол Улсын шил шилээ дагасан эдгээр өрийн бичиг нь олон улсын хөрөнгө оруулагчдыг эрчимтэй татах болсон. Анх Худалдаа хөгжлийн банк 2007 онд 150 сая ам.долларын үнэт цаас олон улсын зах зээлд нэвтрүүлсэн байжээ. Тухайн үед ING банк тус банкинд үнэт цаас арилжаалахад нь тусалж байсан бол энэ удаагийн “Голомт” банкнаас гаргах бондын арилжаанд оролцохгүй юм байна. Сүүлийн үеийн үнэт цаас



нь олон улсын зах зээл дээр хоёрхон өдрийн дотор борлогдсон нь байгалийн баялагт суурилсан Монголын эдийн засгийг улам сонирхолтой болгож байна.

“Юу олны анхаарлыг татаж байна вэ гэхээр Хөгжлийн банкны үнэт цаасны дараагаар ч Монголын уул уурхайн корпорацид дахин 600 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчид байсан явдал” хэмээн ING банкны алхлах төлөөлөгч Ховард Ламберт хэлэв.

Хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улс олон шинэлэг зүйл амлаж байгаа аж. Хятад, Индонез зэрэг хөгжингүй орнуудад бондын арилжаанаас ашиг хүртэх магадлал өндөр байдаг тул хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ өндөр үнэлгээтэй байдаг. Ламбертын хэлж буйгаар тэдгээр орон хөрөнгө оруулагчдын гол бай нь болдог учир зах зээл нь дүүрсэн байдаг гэнэ. Тиймээс хөрөнгө оруулагчид амжилт олох бүрэн боломжтой, гэхдээ шинэ хөрөнгө оруулагчдыг татахуйц өрсөлдөгч гэхээсээ илүүтэйгээр өдөөгч болж чадах тийм зах зээлийг эрэлхийлэх болжээ. Тэдний энэхүү шинэ эрэлхийллийн шалгуурт нийцэж байгаа нь Монгол Улс. Мөн “Энэ нь хөрөнгө оруулагчдын хорхойг хүргэхээс гадна өөр нэг төрлийн адал явдал болж байгаа юм” хэмээн Ламберт хэлсэн.

Хөрөнгө оруулагчид нь Монгол Улсыг дэлхийд таниулах хэрэгсэл аж. 2009 оны эдийн засгийн хүнд үеийг давснаас хойш Монголын хурдацтай хөгжил хөрөнгө оруулагчдын анхаарлыг дээд цэгт нь татах болсон. Одоо Монгол эдийн засгаа өргөжүүлэх улмаар хөрөнгө оруулагчдыг татахад бэлэн болсон хэдий ч хөрөнгө оруулагчдын хувьд тун цөөхөн боломж байгаагаас гадна сөхөөд харчих үнэт цаасны “түүх” бараг үгүй байна.

Санхүүгийн салбарт хөрөнгө оруулах нь Монголын боломжит өсөлтийн үүдийг тогших нэг хэлбэр. Жижиг, дунд үйлдвэрлэл эхлүүлэхэд боловсруулалт, үйлдвэрлэл, өргөтгөлийн зардал гээд байнгын хөрөнгө шаардана. Хэрэв банкуудад хангалттай хөрөнгө байвал тэдэнд зээл олгож болох юм. Ийм шалтгаануудын улмаас өмнө нь “Голомт” болон Худалдаа хөгжлийн банк энгийн хувьцаа худалдаалахдаа олон нэгдлээс тэдгээрийг хуримтлуулсан байна. Харин Монголын банкуудын өрийн бичгийн худалдаа нь нэмэлт хөрөнгө бүрдүүлэх шинэ гарц болж байна.

“Хөгжлийн банк болон Монголын уул уурхайн корпораци, тэдэнтэй төстэй асуудлууд нь Монгол Улс руу хөрөнгийн урсгал татах гол суваг мөн ирэх жилүүдэд өрнөх өсөлтийн катализатор болно” хэмээн Frontier Securities Chief Investment-ийн стратегич Далэ Чой хөрөнгө оруулагчдад зориулсан зурвасдаа тэмдэглэжээ. Мөн тэрбээр дэлхийн эдийн засгийн өнөөгийн сул байдал нь Монголын үнэт цаасны арилжаанд хэрхэн нөлөөлсөн талаар хэлэхдээ “Цаг хугацаа хамгаас чухал байсан” хэмээн тайлбарласан юм.

Урагшлах алхам

Тоглоомын дүрэм өөрчлөгдсөнөөр эдгээр үнэт цаас бүр ч чухал болж болох юм. Moody’s Investor Services Монголын байгууллагуудыг үнэлэх үнэлгээний аргачлалаа дахин боловсруулахаар болжээ. Энэхүү үнэлгээ нь холбогдох байгууллагын бие даасан татвар ногдуулалт бөгөөд тухайн байгууллага зээлээ эргэн төлөх чадвартай эсэхийг үнэлэн гаргадаг.

АНУ-д 2008 онд нүүрлээд байсан зээлийн хямрал болон саяхны евро бүсийн өрийн хямрал санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудыг зээл олгогч улсын Засгийн газартай шууд холбосон шинэ бодлого хэрэгтэйг харуулсан. Монгол банк үйл ажиллагаагаа явуулж буй орондоо л хүчирхэг байгууллага гэдгийг харгалзан

зээлийн үнэлгээ тодорхойлогчид Монголын банкуудыг Засгийн газрын үнэлгээтэй харьцуулан доогуур үнэлэх магадлал бий. “Нэг Засгийн газраар удирдуулж байгаа бүх зээл олгогч байгууллагууд эдийн засаг болон дотоодын банкны системийн дагуу тодорхой түвшинд үнэлэгдэнэ” хэмээн Moodys үнэлгээний шинэ бодлогоо тайлбарласан албан мэдэгдэлдээ дурдсан байна. Мөн уг тайлбарт “Засгийн газраас авч буй батлан хамгаалах зорилго бүхий үйл ажиллагаанд тэдгээр байгууллага обьект нь болно. Тухайн үйл ажиллагаа нь хязгаарлалтын арга хэмжээ, татвар эсвэл дүрэм, журмын өөрчлөлт болон хямралын үед хөдлөнгөөс оролцох эрх зэргийг багтаана” гэжээ. Тус байгууллагын үнэлгээний шинэ бодлогын зөвлөмжийн дагуу өмнө нь үнэлгээнд хамрагдсан Монголын дөрвөн банк санхүүгийн чадлаараа одоогийн “D-” үнэлгээнээс нэг шат доогуур үнэлэгдэнэ гэх таамаг гаргажээ. Аль нэг байгууллага улсынхаа Засгийн газраас хүчирхэг байна гэдэг боломжгүй. Иймээс холбогдох улсын Засгийн газрын үнэт цаасыг (Хөгжлийн банкнаас гаргаж байгаа бондын хувьд хагас бие даасан, Засгийн газраас баталгаажсан) хамгийн найдвартай бонд болгож байгаа юм. Харин нүүрс олборлогч Монголын уул уурхайн корпорацийн хувьд ийм баталгаа гаргах боломжгүй аж. Учир нь, тус байгууллагын санхүүгийн байдал өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнээс шууд хамаардаг. Хэдийгээр үнэлгээний байгууллагаас тус хоёр байгууллагыг ижил түвшинд үнэлсэн байж болох ч Хөгжлийн банк жилийн зургаан хувийн хүүтэй бондыг арилжаалах боломжтой бол Монголын уул уурхайн корпораци есөн хувийн хүүтэйгээр борлуулах жишээтэй.

Монгол Улсыг доогуур үнэлэх нь хөрөнгө оруулагчдыг үргээж чадахгүй аж. Учир нь, тэд ямар баримтаар үнэлгээг гаргаж байгаа болон өмнөх хөрөнгө оруулалтуудаас өөрсдийн дүгнэлтийг гаргах юм. Ирээдүйн хөрөнгө оруулагчид нь өмнөх үнэт цаасны арилжаанд оролцсон эсвэл оролцож чадалгүй үлдсэн хөрөнгө оруулагчид байна гэх таамаг байна.

Ирээдүйд гаргах үнэт цаасны борлуулалт хэр амжилттай байх нь хөрөнгө оруулагчдаас хамаарна. Гэхдээ өмнө нь гаргасан Хөгжлийн банкны 6.2 тэрбум ам.долларын мөн Монголын уул уурхайн корпорацийн 4.9 тэрбум ам.долларын нэмэлт захиалгаас дүгнэхэд гурав дахь, дөрөв дэх бондын арилжаанд хөрөнгө оруулагчид хэтэвчээ нээхэд бэлэн байгаа бололтой.

ЭЛЧИН САЙД БИЧИЖ БАЙНА

АЗИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРААС БИДЭНД СУРАХ ЗҮЙЛ БИЙ ЮУ?



Сүүлийн 30 гаруй жилийн туршид дэлхийн эдийн засагт ноёрхох байр сууриа улам нэмэгдүүлсээр байгаа Зүүн Өмнөд болон Зүүн Хойт Азийн орнууд, тухайлбал, Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Хонконг болон Сингапур улсууд нийгмийн баялгийн үйлдвэрлэл, экспортынхоо өсөлт хэмжээгээр төдийгүй нийгмийн халамжийн бодлого, хөгжлийн загвараараа багагүй анхаарал татах болов.

Б. ЭНХМАНДАХ /Доктор /Ph.D./ Хөгжлийн загварын тухай цуврал №2

Эдийн засгийн үсрэнгүй хөгжилтэй орнуудын тоонд сүүлийн үед манай хөрш Хятад улсыг зүй ёсоор хамааруулан үзэх болсон байна. Нийгмийн хамгааллын эсрэг, зах зээлийн үзэл сурталд илүүтэй тулгуурласан байдлаас нь үндэслэн Азийн үнэт зүйлс нь нийгмийн халамжийн бодлоготой зохицдоггүй гэж үздэг. Гэвч эдгээр оронд бүх нийтийн сайн сайхан нийгмийн сул төлөвшилт нь эдийн засгийн өндөр хөгжлөөрөө нөхцөлдөн улам сайжирч, жилээс жилд төлөвшлөө олсоор байна гэж үзэж болохоор байгаа юм.



Тухайлбал, “нэг улс хоёр тогтолцоо”-ны бодлого хэрэгжиж байгаа шинэ улс төрийн үндэстний хувьд Хонконгд нэг талаас, зах зээл нь төрийн идэвхтэй оролцоог үгүйсгэхийн зэрэгцээ орон сууцны бодлого, боловсрол, эрүүл мэндийн салбар дахь ардчилсан тогтолцоог нийгмийн дундаж давхарга нь дэмжиж байдаг байна.

Япон улсын хувьд өөрсдийн нийгмийн хэрэглээ, хэрэгцээг хангагч жижиг, дунд үйлдвэрлэгчдийн ангитайгаараа онцлогтой. Аж үйлдвэржүүлэлтийн нөлөөн дор Күнзийн соёл, үзэл суртал, улс төрийн байгууламжаа хүртэл сулруулж, уламжлалт консерватизмаас шинэ либерализмд шилжиж, хүчтэй цэрэгжсэн төрийн бодлого нь улам бүр зах зээлийн зарчмыг хатуу баримталсан, бүх нийтийн сайн сайхан нийгмийн бодлогыг хумьсан шинжтэй байдаг. Гэсэн хэдий ч эдгээр эсрэг тэсрэг асуудлуудыг нийгэм дэх эвлэрэл зохицлын зарчмаар ямх ямхаар шийдвэрлэсээр иржээ.

Тайвань улсад нийгмийн халамж, тэтгэвэр болон эрүүл мэндийн даатгал нь Бисмаркийн загвар шиг төрөөс зохицуулагдсан хэлбэртэй байдаг бол БНСУ -ын төрийн дарангуйлал нь иргэний нийгмээ дарамталж, ажилчин ангийн эсэргүүцлийг дарж, нийгмийн сайн сайхны сонголтыг хязгаарлаж ирсэн. Хэдий тийм боловч улам боловсронгуй болсоор буй ардчилсан сонгуулийн үйл явц, түүний цаашдын өрнөлт нь бүх нийтийн сайн сайхан нийгмийн “үлдэгдлийн” чанартай бодлогыг “тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг” болгоход бага багаар хүргэсээр байна.

Харин Сингапур эдийн засгийн улс төржсөн хандлагатай бодлогынхоо үр дүнд төвлөрлийн зарчмын тогтвортой орчин нь нийгмийн хамгааллын, түүний дотор даатгалын нэгдсэн тогтолцоог төлөвшүүлж чадсан байдаг онцлогтой .

Монгол орны хөгжлийн загварыг тодорхойлохын тулд эдгээр орны туршлагыг судалж, Азийн нийгмийн хөгжлийн загвараас суралцахын тулд орон бүрийн онцлог, олон төрөлт байдал, хэтийн төлөвийг нарийвчлан авч үзэж, Барууны буюу Европын нийгмийн хөгжлийн загваруудтай харьцуулан үзэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Судлаачид Азийн дээр нэр дурдсан орнуудыг хөгжлийн загварынх нь хувьд ихэнх тохиолдолд “Күнзийн бүх нийтийн сайн сайхан нийгмийн орнууд” / Confucian Welfare States/ гэж нэрлэж байна.

Эн тэргүүн Күнзийн сургаалд тулгуурласан соёл, сэтгэлгээний ерөнхий түвшин, хоёрдугаарт, эдийн засгийн хувьд хүчирхэг төр, гуравдугаарт, төрийн захиргааны /төсвийн/ харьцангуй бага зардал, дөрөвдүгээрт, төрийн үүргийг орлон гүйцэтгэх төр, хувийн хэвшлийн хосолсон PPP(Public private partnership) чадварлаг тогтолцоо, тавдугаарт, эрх зүйн чадамжийн хувьд сул боловч төвлөрлийг сааруулсан зэрэг нь дээрх орнуудын түгээмэл шинж гэж хэлж болно. Күнзийн үзэл санаа улс төрийн төдийгүй хувь хүн, гэр бүлийн сэтгэлгээний үндэс болсон эдгээр оронд хөдөлмөрийн хуваарь, нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн асуудлууд ганцхан хариултаар хариулагдах, ганц шийдвэрээр хэрэгжих асуудлууд биш нь ойлгомжтой. Хувь хүн, нийгмийн бүлэг, тэр байтугай төрийн зүгээс аливаа асуудалд өөр өөрийн байр сууринаас хандах нь хэвийн үзэгдэл болно.

Гэсэн хэдий ч хүн амын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд болон нийгмийн хамгаллын ерөнхий тогтолцооны асуудлуудад нийгмийн олонхийн байр сууринаас хандах болсонд Азийн “бар”, “луу” гэгдэж буй эдгээр орны нийгмийн хөгжлийн загварын онцлог оршиж байх шиг байгаа юм.

Үргэлжлэл бий